УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ ТҮВШИН ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

ПАРЛАМЕНТЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

Графикийн жагсаалт 3

Хүснэгтийн жагсаалт 5

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ 7

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ 7

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ 8

Судалгаанд хамрагдагсдын хүн ам зүйн үзүүлэлт 10

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ, НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ 12

1.1 УИХ-ын ерөнхий үнэлгээ 12

1.2 УИХ-ын стратеги төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ 17

1.3 УИХ-ын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээнд нөлөөлөгч хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ 20

1.4 Одоогийн УИХ-аас хүлээж буй иргэдийн хүлээлт 23

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАЖ БУЙ БАЙДАЛ 25

Гурав. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ САНААЧЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ 43

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ 52

Тав. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ 75

Зургаа. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 81

ДҮГНЭЛТ, САНАЛ 92

Хавсралт (харьцуулсан үр дүнгийн график) 101

СУДАЛГААНЫ БАГ

ТАНИЛЦСАН: Д.Бумдарь, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал

Тайлан бичсэн: П.Түмэнцэцэг, Парламентын хөгжлийн хэлтсийн дарга

Мэдээллийн найдвартай байдлыг хангаж ажилласан: Б.Намнанбаяр, Парламентын хөгжлийн хэлтсийн Санал асуулга хариуцсан судлаач

Судалгааны мэдээлэл цуглуулсан: Вай Инсайт ХХК

Графикийн жагсаалт

График 1. Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ?.....12
График 2. Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр).....13
График 3. Одоогийн 126 гишүүнтэй парламент 76 гишүүнтэй байсан өмнөх парламенттай харьцуулахад хэр зэрэг ажиллаж байна гэж Та бодож байна вэ?.....14
График 4. Та УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн танилцуулсан Парламент 2.0 "Гурван төгөлдөршил" илтгэлийн талаар мэдээлэлтэй байгаа юу?.....15
График 5. УИХ-ын дундаж болон нөлөөлөгч хүчин зүйлийн дундаж үнэлгээ.....19
График 6. УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал.....25
График 7. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ?.....26
График 8. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр).....28
График 9. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ? 30
График 10. Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ?.31
График 11. Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр).....33
График 12. Та дараах хариултын хувилбаруудаас УИХ-ын чиг үүргийг сонгоно уу?.....35
График 13. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? 36
График 14. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 38
График 15. Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу? 39
График 16. Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 41
График 17. Та ямар хэлбэрээр УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлж байсан бэ? ..42
График 18. УИХ-ын хууль санаачлах чиг үүрэгт өгсөн иргэдийн үнэлгээ 43
График 19. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? 44
График 20. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 45
График 21. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу? 46
График 22. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 48
График 23. Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу?.....49
График 24. Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр).....51
График 25. УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ.....52

График 26. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү? 53
График 27. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 55
График 29. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу? 58
График 30. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 60
График 31. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу? 62
График 32. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 64
График 33. Та “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? 65
График 34. Та “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 67
График 35. Та “Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? 68
График 36. Та “Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 69
График 37. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? 70
График 38. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 72
График 39. УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ 75
График 40. Та нийт УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ? 76
График 41. Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? 77
График 42. Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 78
График 43. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? 79
График 44. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 80
График 45. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын үнэлгээ 81
График 46. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу? 82
График 47. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр) 83
График 48. Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? 84

График 49. Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)....86
График 50. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү?....87
График 51. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)....89
График 52. Өнөөдөр манай улсад тулгамдаж буй хамгийн чухал асуудал юу байна вэ?..90

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Судалгааны төрөл.... 8
Хүснэгт 2. Судалгаанд хамрагдагсдын оршин суугаа газар, дүүрэг....10
Хүснэгт 3. Судалгаанд хамрагдагсдын оршин суугаа аймаг, байршил....10
Хүснэгт 4. Судалгаанд хамрагдагсдын насны бүлэг, хүйс....10
Хүснэгт 5. Судалгаанд хамрагдагсдын ажил эрхлэлт, боловсрол....10
Хүснэгт 6. Судалгаанд хамрагдагсдын өрхийн дундаж орлого болон амьжиргаа....11
Хүснэгт 7. Фокус бүлгийн ярилцлагын түүвэр....11
Хүснэгт 8. Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)....12
Хүснэгт 9. УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээнд нөлөөлөгч хүчин зүйлийн коррелиацын хамаарлын шинжилгээ....20
Хүснэгт 10. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)....26
Хүснэгт 11. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ? (Насны бүлгээр)....30
Хүснэгт 12. Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)....32
Хүснэгт 13. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)....37
Хүснэгт 14. Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)....40
Хүснэгт 15. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) .44
Хүснэгт 16. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)....47
Хүснэгт 17. Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)....49
Хүснэгт 18. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)....53
Хүснэгт 19. Хаанаас үйлчилгээ авахад ямар хэлбэрээр эрх тань зөрчигдсөн бэ?....56

Хүснэгт 20. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 58
Хүснэгт 21. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 62
Хүснэгт 22. Та "Монголын хууль 3 хоног л үйлчилдэг" гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 66
Хүснэгт 23. Та "Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг" гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 68
Хүснэгт 24. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 71
Хүснэгт 25. Хуулиар шийдвэрлэж чадаагүй ямар асуудал байсан бэ? 73
Хүснэгт 26. Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 77
Хүснэгт 27. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 79
Хүснэгт 28. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 82
Хүснэгт 29. Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 85
Хүснэгт 30. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ) 87

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаа: 2025.8.14-2025.8.29

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны хэрэгцээ шаардлага, зорилго

2024 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулиар 126 гишүүнтэй парламент бүрдэн үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт “Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ” хэмээн заасны дагуу УИХ-ын даргын 2024 оны 71 дүгээр захирамжаар “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын дэд дарга Х.Булгантуяагаар ахлуулан байгуулсан юм. Ажлын хэсэг Олон улсын парламентын холбоо болон бусад орны сайн туршлага, УИХ-ын 2019-2024 стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, УИХ-ын үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны дүн, эрдэмтэн судлаачидтай хийсэн хоёр удаагийн хэлэлцүүлэгт оролцогчдын саналыг судлан үзэж УИХ-ын ирэх дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулжээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөөг баталж, **хэрэгжилтэд жил тутам мониторинг**, хоёр жил тутамд үр нөлөөний үнэлгээ хийж, Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын хороонд танилцуулна” гэж шийдвэрлэсэн.

Стратеги төлөвлөгөөнд жил тутам үнэлгээ хийснээр, Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц дахь олоltыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид стратеги төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох чиглэлд дүгнэлт, санал гаргах юм.

Энэ удаагийн судалгааг Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны Стратеги төлөвлөлтийн хэрэгжилтийг үнэлж, суурь түвшнийг тогтоох зорилготой болно.

- **СУДЛАХ ЗҮЙЛ, СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ОБЪЕКТ**

Судлах зүйл: Монгол Улсын Их хурал болон Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагаа, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хууль тогтоомжийн хэрэгжилт, улс төрийн нөхцөл байдал

Судалгааны хамрах хүрээ, объект:

- Үндэсний хэмжээнд буюу бүсээс нэг аймаг, сум (Баруун бүс: Говь-Алтай аймгийн төв, Дэлгэр сум, Хангайн бүс: Хөвсгөл аймгийн төв, Их-Уул сум, Төвийн бүс: Сэлэнгэ аймгийн төв, Мандал сум, Зүүн бүс: Хэнтий аймгийн төв, Батноров сум, Нийслэлийн Налайх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг)
- 18-аас дээш настай нам бус иргэн

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

❖ Мэдээлэл цуглуулах арга

Хүснэгт 1. Судалгааны төрөл

№	Судалгааны арга	Зорилго	Үр дүн
1	Асуулгын арга	Иргэд, олон нийт УИХ болон УИХ-ын гишүүний үйл ажиллагаа, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хууль тогтоомжийн хэрэгжилт, улс төрийн нөхцөл байдлыг тодорхойлж, цаашид анхаарах асуудлаар дүгнэлтэд суурилсан санал гаргах.	Давтамж, өгөгдөлд шинжилгээ хийж, тоон дүнгээр илэрхийлэх.
2	Фокус бүлгийн ярилцлага	Иргэд, олон нийтээс авсан асуулга судалгааны тоон дүнг батлах, шалтгааныг тодорхойлох.	Тоон дүнг чанарын судалгаагаар баталгаажуулж, судалж буй асуудлын талаарх ойлголт, шалтгаан, үр дагаврыг тодорхойлох.

❖ Судалгааны түүвэр

- **Асуулга судалгааны түүвэр**

Судалгааны түүврийн хэмжээг тогтоохдоо социологийн судалгаанд өргөн хэрэглэгддэг статистик болон эмпирик аргуудыг хослуулан хэрэглэсэн болно.

Монгол улсын хэмжээнд хийгддэг суурь судалгаануудаас үзвэл түүврийн дундаж хэмжээ 1100:1 харьцаатай байдаг бол Олон улсын жишигт эх олонлогийг төлөөлж чадахуйц түүврийн хэмжээг 5000:1 гэсэн харьцаатай сонгох нь түгээмэл байдаг.

Түүвэрлэлт хийх онолын үндэс нь хэвийн тархалт байдаг. Энэ нь магадлалд үндэслэдэг. Нэгэнт түүвэрлэлт хийх аргачлал нь магадлалын онол, математик статистикаар боловсруулагдсан байдаг учраас бид тэрхүү аргачлалыг өөрийн судалгааны зорилго, судалгаа хийх бүс нутгийнхаа нийгэм, хүн ам зүйн онцлогт тулгуурлан хэрэглэх боломжтой.

$$n = \frac{t^2 \cdot w \cdot (1-w) \cdot N}{N \cdot \Delta_p^2 + t^2 \cdot w \cdot (1-w)}$$

Сонгуулийн Ерөнхий хорооноос гаргасан 2024 оны УИХ-ын сонгуульд оролцох нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын тоо 2,089,949 байна. Түүврийн хэмжээг ±5 хувийн алдааны магадлалтай, 95 хувийн итгэх түвшинтэйгээр тооцоход 385 гарч байгаа юм. Алдааны магадлалыг бууруулах зорилгоор нийт 1,522 хүнийг асуулга судалгаанд хамруулсан.

- **Фокус бүлгийн ярилцлагын түүвэр**

Фокус бүлгийн ярилцлагыг Говь-Алтай, Хөвсгөл, Сэлэнгэ, Хэнтий аймгийн төв, Налайх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэгт тус бүр нэг удаа, нийт 7 удаа хийсэн.

Нэг удаагийн ярилцлагад нас, хүйсийн доорх хүснэгт дэх шаардлагад нийцэх 10 хүнийг хамруулна. Мөн ярилцлагад оролцогчийг бүрдүүлэхдээ боловсрол (дээд болон бусад), ажил эрхлэлт (төрийн байгууллага болон хувийн хэвшил), оршин суугаа газар (гэр хороолол, орон сууцны хороолол, хөдөө) зэргийг харгалзаж, түүврийн төлөөлөх чадварт анхаарч ажилласан.

❖ **Судалгааны мэдээлэл цуглуулах арга**

Судалгааг нийгмийн эмпирик судалгааны тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан хийнэ. Тоонд судалгааны хүрээнд асуулгын (анкетын) нүүр тулсан ярилцлагын аргыг (Face-to-Face-interview) ашиглах бол, чанарын судалгааны хүрээнд фокус бүлгийн хэлэлцүүлгийн (focus group discussion) аргыг ашигласан.

❖ **Судалгааны мэдээлэлд боловсруулалт хийсэн арга**

Тоон судалгааны үр дүнг судалгааны боловсруулалтын SPSS 26 программ ашиглаж хийсэн. Зарим хамаарлын шинжилгээг хийхдээ хамаарах болон үл хамаарах хувьсагчийн бүлгийг тодорхойлж, 1-ээс 5 хүртэлх онооны нийлбэр үр дүнд үндэслэн 0-оос 1 хүртэлх онооны интервалд шилжүүлсэн.

Фокус бүлгийн ярилцлагын бичлэгийг бичгээр буулгаж, матрицад хүргүүлэн, үр дүнд шинжилгээ хийсэн болно.

Судалгаанд хамрагдагсдын хүн ам зүйн үзүүлэлт

1. Асуулга судалгаанд хамрагдагсдын хүн ам зүйн үзүүлэлт

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдагсдын оршин суугаа газар, дүүрэг

Харьяалал	Тоо	Хувь	Дүүрэг	Тоо	Хувь
Улаанбаатар хот	732	48%	Сонгинохайрхан	476	65%
Аймаг, орон нутаг	790	52%	Чингэлтэй	198	27%
Нийт	**1522**	**100%**	Налайх	58	8%
			Нийт	**732**	**100%**

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдагсдын оршин суугаа аймаг, байршил

Аймаг	Тоо	Хувь	Байршил	Тоо	Хувь
Говь-Алтай	139	18%	Аймгийн төв	545	69%
Сэлэнгэ	307	39%	Сумын төв	224	28%
Хөвсгөл	171	22%	Хөдөө	21	3%
Хэнтий	173	22%	**Нийт**	**790**	**100%**
Нийт	**790**	**100%**			

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдагсдын насны бүлэг, хүйс

Насны бүлэг	Тоо	Хувь	Хүйс	Тоо	Хувь
18-24 нас	223	15%	Эрэгтэй	759	50%
25-34 нас	324	21%	Эмэгтэй	763	50%
35-44 нас	354	23%	**Нийт**	**1522**	**100%**
45-54 нас	279	18%			
55-аас дээш	342	22%			
Нийт	**1522**	**100%**			

Хүснэгт 5. Судалгаанд хамрагдагсдын ажил эрхлэлт, боловсрол

Ажил эрхлэлт	Тоо	Хувь	Боловсрол	Тоо	Хувь
Төрийн алба	213	14%	Байхгүй/Бага сургууль	40	3%
Хувийн хэвшил	768	50%	Бүрэн бус дунд	152	10%
Оюутан, сурагч	106	7%	Бүрэн дунд	767	50%
Тэтгэвэр, групп	261	17%	Тусгай дунд (мэргэжлийн боловсрол)	98	6%
Цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй	120	8%	Дээд/Бакалавр	432	28%
Малчин	50	3%	Магистраас дээш	33	2%
Хариулахыг хүсэхгүй байна	4	0.3%	**Нийт**	**1522**	**100%**
Нийт	**1522**	**100%**			

Хүснэгт 6. Судалгаанд хамрагдагсдын өрхийн дундаж орлого болон амьжиргаа

Өрхийн дундаж орлого	Тоо	Хувь	Өрхийн амьжиргаа	Тоо	Хувь
400,000 хүртэлх	68	4%	Хоол хүнсэндээ ч хүрдэггүй	188	12%
400,001-800,000 төгрөг	165	11%	Хоол хүнсэндээ хүрдэг ч хувцас хунарт хүрдэггүй	361	24%
800,001-1,200,000 төгрөг	220	14%	Хувцас хунар авахад хүрээд зурагт, хөргөгч мэтийн гэр ахуйн	380	25%
1,200,001-1,800,000 төгрөг	299	20%	Хөргөгч, зурагт мэтийн гэр ахуйн юм авахад хүрээд машин	244	16%
1,800,001-2,500,000 төгрөг	323	21%	Машин авахад мөнгө хүрээд, байр авахад хүрэхгүй байгаа	176	12%
2,500,001-4,000,000 төгрөг	292	19%	Ямар нэг санхүүгийн асуудал байхгүй, хэрэгтэй болсон бүх	129	8%
4,000,001 ба түүнээс дээш	155	10%	Илүү гарсан орлогоо хадгаламжид хийдэг	44	3%
Нийт	**1522**	**100%**	**Нийт**	**1522**	**100**

2. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт

Хүснэгт 7. Фокус бүлгийн ярилцлагын түүвэр

Бүс	Аймаг/дүүрэг	Нийт тоо	18-24 нас		25-29 нас		30-39 нас		40-49 нас		50-аас дээш нас	
			Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Баруун бүс	Говь-Алтай аймгийн төв	10	1	1	1	1	1	1	1	1	1	1
Хангайн бүс	Хөвсгөл аймгийн төв	13	1	1	1	1	1	2	1	2	2	1
Төвийн бүс	Сэлэнгэ аймгийн төв	10	1	1	1	1	1	1	1	1	1	1
Зүүн бүс	Хэнтий аймгийн төв	10	1	1	1	1	1	1	1	1	1	1
Улаанбаатар хот	Налайх дүүрэг	11	1	1	1	1	1	1	1	1	1	2
	Сонгинохайрхан дүүрэг	10	1	1	1	1	1	1	1	1	1	1
	Чингэлтэй дүүрэг	10	1	1	1	1	1	1	1	1	1	1
Нийт		**74**	**7**	**7**	**7**	**7**	**7**	**8**	**7**	**8**	**8**	**8**

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ, НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ


1.1 УИХ-ын ерөнхий үнэлгээ

УИХ-ын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт хэр зэрэг байгаагаас хамаарч УИХ-ын ерөнхий үнэлгээ гарна гэж үзэж гол асуултаар “Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ?” гэх асуултыг сонгосон.

Судалгааны дүнгээс харвал, УИХ-ын үйл ажиллагааг 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.4 гарсан. Өөрөөр хэлбэл одоогийн УИХ-ын үйл ажиллагааг сайн гэж судалгаанд оролцогчдын 4%, дунд зэрэг гэж 41%, муу гэж 47% нь хариулжээ.

График 1. Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ?

Дундаж үнэлгээ: 2.4



Тайлбар: *Маш сайн бол 5, маш муу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харвал, оршин суугаа газар, насны бүлэг, хүйс, ажил эрхлэлт, өрхийн амьжиргаагаар ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 8. Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[1]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.167**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.019**
Боловсролын түвшин	**0.451**
Ажил эрхлэлт	**0.002**
Өрхийн дундаж орлого	**0.092**
Амьжиргаа	**0.001**


[1] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

УИХ-ын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

Бага зэргийн ялгаатай байдлыг харвал, аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 настай, эмэгтэй, оюутан сурагч болон малчид, амьжиргааны хувьд хоол хүнс, хувцас хунар гэх зэрэг анхан шатны хэрэглээгээ хангасан болон санхүүгийн асуудалгүй хүмүүс УИХ-ын үйл ажиллагааг илүү сайн үнэлсэн.

Нөгөө талаас, УИХ-ын үйл ажиллагааг дунджаас багаар үнэлсэн нийгмийн бүлгийг Улаанбаатар хотод амьдардаг, 35-44 настай, эрэгтэй, хувийн хэвшилд ажилладаг болон цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй, орлого нь хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй хүмүүс бүрдүүлж байна.

График 2. Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)



Фокус бүлгийн ярилцлагаар одоогийн УИХ-ын үйл ажиллагааг хэрхэн үнэлж буйг тодруулахад, судалгаанд оролцогчдын олонх нь ард иргэдийн амьдралд бодит өөрчлөлт авчраагүй, үр дүнгүй ажиллаж байна гэж шүүмжилсэн ч цөөн хүн өнгөрсөн нэг жилийн хугацаанд тодорхой хэмжээний ахиц гаргаж байгаа гэж үзэж байна. Тодруулбал:


- ✓ *Одоогийн УИХ-ын үйл ажиллагааг муу гэж дүгнэж байгаа шалтгааныг харвал, иргэдийн амьдралд мэдэгдэхүйц ахиц гараагүй, хэдийгээр цалин, тэтгэвэр нэмсэн ч өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн гэж үзсэн.*
- ✓ *Харин УИХ-ын үйл ажиллагааг сайн гэж үнэлсэн нь УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн удирдлагын арга барил, иргэд, олон нийтэд тулгамдсан асуудлыг нээлттэй ярьж, мэдээллийг ил тод өгдөг болсон гэсэн үндэслэлтэй байна.*
- ✓ *Зарим нь улс төрийн үйл ажиллагааг анхаарч хардаггүй, УИХ-ын талаарх мэдээллийг авдаггүй, УИХ-д итгэх итгэлгүй болсон иргэдийн хувьд УИХ-ын үйл ажиллагааг төдийлөн ойлгодоггүй, одоо юу хийж байгааг нь мэдэхгүй гэж хариулжээ.*

Монгол Улсын Их Хурлын сонгууль 2024 онд холимог тогтолцоогоор, томсгосон тойргийн хэмжээнд явагдаж, тойргоос 78, намын жагсаалтаар 48 гишүүн сонгогдож, одоогийн 126 гишүүнтэй УИХ бүрдэж, үйл ажиллагаагаа явуулж эхлээд нэг жилийн хугацааг ардаа орхиод байна.

Энэ хугацаанд “одоогийн 126 гишүүнтэй парламент 76 гишүүнтэй байсан өмнөх парламенттай харьцуулахад хэр зэрэг ажиллаж байгааг иргэд, олон нийтээр 1-ээс 5 оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.2 гарсан. Өөрөөр хэлбэл, иргэдийн 5% нь сайн, 27% нь дунд зэрэг, 55% буюу иргэдийн талаас илүү хувь нь муу гэж үнэлжээ.

График 3. Одоогийн 126 гишүүнтэй парламент 76 гишүүнтэй байсан өмнөх парламенттай харьцуулахад хэр зэрэг ажиллаж байна гэж Та бодож байна вэ?

Дундаж үнэлгээ: 2.2



Тайлбар: *Маш сайн бол 5, маш муу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*


Фокус бүлгийн ярилцлагаар дээрх асуултыг асуухад иргэдийн олонх нь УИХ 126 гишүүнтэй болсноор мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй, харин ч хангалтгүй ажиллаж байна гэж дүгнэсэн бол цөөнх нь сайжирна гэсэн хүлээлтийн байр суурьтай байна. Тодруулбал:

- ✓ *Одоогийн 126 гишүүнтэй УИХ өмнөх 76 гишүүнтэй байсан УИХ-тай харьцуулахад хангалтгүй ажиллаж байна гэж үзэхдээ, гишүүдийн тоо өссөн ч чанар сайжраагүй, үр дүн нь гараагүй байна. Олон хүн нэмэгдсэнээр төсөвт ачаалал нэмэгдэж, татвар төлөгч иргэдийн нуруун дээр дарамт болсон гэж шүүмжилж байна.*
- ✓ *Харин сайжирсан харж буй цөөн хүмүүсийн үндэслэл нь илүү хүлээлтийн шинжтэй байна. Тодруулбал, УИХ-ын гишүүн 126 болсноор иргэд олон нийтийг УИХ-д төлөөлөх төлөөлөл нэмэгдэж, төлөөлөх үүргээ биелүүлэх боломж бүрдсэн. Энэ агуулгаараа иргэдийн санал бодлыг бодлогын шийдвэрт тусгаж, нэг нэгэндээ хяналт тавьж, илүү чанартай хууль батлах боломж бүрдэнэ гэсэн хүлээлт бий болжээ.*

УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн танилцуулсан Парламент 2.0 “Гурван төгөлдөршил” илтгэлийн талаар мэдээлэлтэй байгаа эсэхийг 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 1.4 буюу муу гарсан. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогчдын 13% нь ямар нэг байдлаар тус мэдээллийг авсан бол 85% нь мэдээлэлгүй байна.

График 4. Та УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн танилцуулсан Парламент 2.0 “Гурван төгөлдөршил” илтгэлийн талаар мэдээлэлтэй байгаа юу?

Дундаж үнэлгээ: 1.4



Тайлбар: *Маш их бол 5, огт үгүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Фокус бүлгийн ярилцлагын хүрээнд судалгаанд оролцогчдоос Та УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн танилцуулсан Парламент 2.0 "Гурван төгөлдөршил" илтгэлийн талаар сонссон эсэх, сонссон бол хэрхэн ойлгож байгааг тодруулахад, тус илтгэлийг олонх нь сонсоогүй, сонссон нэг нь дараах байр суурийг илэрхийлсэн. Тодруулбал:

- ✓ *Цөөн хүн эрэг байр сууриас тус асуудалд хандахдаа, төрийн байгууллагын илүүдэл орон тоо, ажлын зохион байгуулалт, дагалдах хууль тогтоомжийн алдаа гэх мэт бодит асуудлыг хөндөж байгаа нь зөв гэж үзсэн.*
- ✓ *Харин дийлэнх хүмүүс шүүмжлэхдээ, УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн өөрийн мэргэжил, туршлагыг шүүмжилж (хуульч биш, эдийн засагч биш, яаж ийм бодлого тодорхойлох юм…гэх мэт), хэдийгээр сайн хууль санаачилсан ч хэрэгжилт сул, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл хүнд, хүн төвтэй хууль санаачилна гэсэн хэр нь татвар нэмж, татварын дараамтыг нэмэгдүүлсэн нь амьдрал дээр зөрчилдөж байна гэж шүүмжилсэн.*

Парламент 2.0 "Гурван төгөлдөршил" *бодлогын хүрээнд "Хүн төвтэй хууль эрх зүйн орчин", "Цаг үеийн шаардлагад бүрэн нийцсэн хууль бий болгох", "Иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль, эрх зүйн орчин"-ыг бий болгоно гэж тодорхойлсон бөгөөд энэхүү бодлогод тулгуурлан Монгол Улсын Их Хурлын 2024 2028 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Энэ агуулгаар бид уг судалгааны хүрээнд дээрх үндсэн 3 ойлголтыг иргэд хэрхэн ойлгож буй тодорхойлохыг зорьсон.*

Тэгвэл фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос ***"Хүн төвтэй хууль эрх зүйн орчин"*** *гэдэг үгийг хэрхэн ойлгож буйг тодруулахад, тухайн нэршлийг дийлэнх иргэд сонсож байгаагүй байна. Сонсоод хэрхэн ойлгож буйг тодруулахад, "иргэн хүндээ ээлтэй хууль батлах", "ард иргэд рүү чиглэсэн хууль" зэргээр ойлгож, гэсэн ч бодит амьдрал дээр хэрэгждэггүй, хэрэгжих боломжгүй зүйл гэж үзэж байна.*

Хэрэгжих боломжгүй гэж үзэж буй шалтгааныг харвал, "хууль дүрэм нь энгийн ард иргэдэд л дарамт болж үйлчилдэг, харин өндөр албан тушаалтнуудад үйлчлэхгүй", "УИХ өөрсдөдөө хэрэгтэй хууль баталдаг", "улсын төсвөөс хувьдаа завшсан эрх мэдэл бүхий хүмүүст хууль үйлчилдэггүй" зэргийг дурдсан.

"Цаг үеийн шаардлагад бүрэн нийцсэн хууль бий болгох" гэдэг үгийг *дийлэнх иргэд сонсож байгаагүй гэж хариулсан. Сонсоод хэрхэн ойлгож буйг тодруулахад, "Оюутны байр, сургалтын төлбөрийг хөнгөлөх хууль хэрэгтэй", "иргэддээ ээлтэй хууль" гэх мэт иргэдийн тухайн үеийн хэрэгцээнд нийцсэн хууль батлахыг ойлгож байна гээд өнөөдрийн байдлаар ийм хууль батлагдаж, бодитоор хэрэгжээгүй байна гэж шүүмжилж байна.*

Одоо хэрэгжиж байгаа хуулиас хамгийн түгээмэл нь эрүүгийн хууль, замын хөдөлгөөний тухай хууль, зөрчлийн хууль зэргээр хүний эрхийг хязгаарласан, торгууль тавих зорилготой хууль л байгааг зарим иргэд онцолсон.

"Иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль, эрх зүйн орчин" гэдэг үгийг *дийлэнх иргэд сонсож байгаагүй гэж хариулсан. Сонсоод хэрхэн ойлгож буйг тодруулахад, нэг асуудлыг иж бүрнээр шийдсэн, тодорхой ойлгомжтой хууль гэж ойлгож, гишүүд аливаа хууль санаачлахдаа шаардлагатай зүйлсийг судалчихсан байдаг байх гэсэн хуулийн чанарын талаар эерэг төсөөлөл бүхий тайлбарыг өгсөн.*

Гэсэн хэдий ч Монголчууд хуулиа мэддэггүй, хэрэгтэй үедээ өөрт хэрэгтэй хуулийн нэг заалт л хардаг. Өнөөдрийн байдлаар Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль зэрэг өдөр тутмын амьдралд тулгардаг асуудалтай холбоотой хуулийг гадарладаг гэжээ.

Монгол Улсын Их Хурал "Хүн төвт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлнэ" гэсэн зорилго тавьсан. Тус зорилгоо биелүүлж чадах болов уу? *Гэж асуухад дийлэнх иргэд төрийн бодлого амьдралд бууж, хэрэгжихгүй байгааг иш татаж, хэрэгжихгүй, хэрэгжинэ гэдэгт итгэлгүй байна гэж хариулсан.*

Цөөн хүн эерэг байр суууриас хандахдаа, зорилго тавьсан юм чинь тус зорилгодоо хүрээсэй, хичээх хэрэгтэй гэж дэмжсэн сэтгэгдлээ илэрхийлжээ.

1.2 УИХ-ын стратеги төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ

УИХ-ын стратеги төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг харгахдаа асуулга дахь үзүүлэлтүүдийг хамгийн багадаа 1, хамгийн өндөр 5 буюу 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлж дараах 4 бүлэгт ангилж, дундаж үнэлгээг гаргасан.


1. УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй эсэх:
    - Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ?
    - Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ?
    - Та дараах хариултын хувилбаруудаас УИХ-ын чиг үүргийг сонгоно уу?
    - Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу?
    - Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу?
2. УИХ-ын хууль санаачлах чиг үүргийн хэрэгжилт:

- Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ?
- Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу?
- Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу?

3. УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хэрэгжилт:
    - Өнгөрсөн онд төрийн байгууллагаас ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү?
    - Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу?
    - Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу?
    - Та “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ?
    - Та "Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг" гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ?
    - Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу?
4. УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүргийн хэрэгжилт:
    - Та нийт УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ?
    - Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу?
    - Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу?
5. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал:
    - Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу?
    - Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ?
    - Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү?

Ийнхүү 5 бүлэг тус бүрийн дундаж үнэлгээг хооронд нь нэмж, УИХ-ын үнэлгээг гаргахад 2.5 буюу дунд зэрэг гэсэн үнэлгээ гарсан.

График 5. УИХ-ын дундаж болон нөлөөлөгч хүчин зүйлийн дундаж үнэлгээ



1.3 УИХ-ын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээнд нөлөөлөгч хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ

УИХ-ын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээний дундаж 2.4 гарсан. Тус дүнд УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдлын дундаж дүн+ УИХ-ын хууль санаачлах чиг үүргийн хэрэгжилтийн дундаж дүн+УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийн дундаж дүн+УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийн дундаж дүн болон Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хүчин зүйл нөлөөлж буй эсэхэд коррелиацын хамаарал тооцож үзэхэд, бүгд хамааралтай буюу статистикийн хувьд ач холбогдолтой гэх дүн гарсан.

Хүснэгт 9. УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээнд нөлөөлөгч хүчин зүйлийн коррелиацын хамаарлын шинжилгээ

Correlations

		УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал	УИХ-ын хууль санаачлах чиг үүрэг	УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг	УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүрэг	Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал	**УИХ-ын үнэлгээ**
УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал	Pearson Correlation	1	.148**	.050*	.154**	.089**	.123**
	Sig. (2-tailed) [2]		**.000**	.050	**.000**	**.001**	**.000**
	N	1522	1522	1522	1522	1522	1522
УИХ-ын хууль санаачлах чиг үүрэг	Pearson Correlation	.148**	1	.454**	.403**	.407**	.337**
	Sig. (2-tailed)	**.000**		**.000**	**.000**	**.000**	**.000**
	N	1522	1522	1522	1522	1522	1522
УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг	Pearson Correlation	.050*	.454**	1	.444**	.420**	.380**
	Sig. (2-tailed)	.050	**.000**		**.000**	**.000**	**.000**
	N	1522	1522	1522	1522	1522	1522
УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүрэг	Pearson Correlation	.154**	.403**	.444**	1	.399**	.485**
	Sig. (2-tailed)	**.000**	**.000**	**.000**		**.000**	**.000**
	N	1522	1522	1522	1522	1522	1522
Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал	Pearson Correlation	.089**	.407**	.420**	.399**	1	.375**
	Sig. (2-tailed)	**.001**	**.000**	**.000**	**.000**		**.000**
	N	1522	1522	1522	1522	1522	1522
УИХ-ын үнэлгээ	Pearson Correlation	.123**	.337**	.380**	.485**	.375**	1
	Sig. (2-tailed)	**.000**	**.000**	**.000**	**.000**	**.000**	
	N	1522	1522	1522	1522	1522	1522

**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

[2] *Sig. (p-value) нь регрессийн модель бүхэлдээ утга бүхий эсэхийг шалгаж өгдөг үзүүлэлт юм. p < 0.05 Модель бүхэлдээ статистикийн хувьд утга бүхий буюу статистикийн хувьд ач холбогдолтой. p ≥ 0.05 → Модель утга бүхий биш буюу статистикийн хувьд ач холбогдолгүй.*

УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал, УИХ-ын хууль санаачлах болон хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал, УИХ-ын гишүүний чиг үүрэг, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын иргэдийн үнэлгээ зэрэг нь УИХ-ын үнэлгээнд хэрхэн нөлөөлж байгааг энэ дэд бүлэгт харуулсан.

УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээнд дараах 5 үзүүлэлт (УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал, УИХ-ын хууль санаачлах болон хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал, УИХ-ын гишүүний чиг үүрэг, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын иргэдийн үнэлгээ) R=0.546 буюу дунд зэрэг хүчтэй эерэг хамааралтай байна. Хэрвээ тус 5 үзүүлэлтэд нэгэн зэрэг өөрчлөлт орвол R Square=0.298 буюу 29.8%-аар өөрчлөлт орох боломжтой.

Model Summary

Model	R[3]	R Square[4]	Adjusted R Square	Std. Error of the Estimate
1	**.546[a]**	**.298**	.296	.1699

a. Predictors: (Constant), УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал, УИХ-ын хууль санаачлах болон хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал, УИХ-ын гишүүний чиг үүрэг, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын иргэдийн үнэлгээ

УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал, УИХ-ын хууль санаачлах болон хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал, УИХ-ын гишүүний чиг үүрэг, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын иргэдийн үнэлгээ зэрэг нь УИХ-ын үнэлгээнд хамааралтай буюу Sig=0.000 байна.

ANOVA[a]

Model		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.[5]
1	Regression	18.561	5	3.712	128.655	**.000[b]**
	Residual	43.744	1516	.029		
	Total	62.305	1521			

a. Dependent Variable: УИХ-ын үнэлгээ

b. Predictors: (Constant), УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал, УИХ-ын хууль санаачлах болон хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал, УИХ-ын гишүүний чиг үүрэг, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын иргэдийн үнэлгээ

---

[3]R нь хамааралтай хувьсагч ба моделд орсон бие даасан хувьсагчид-ын хоорондын шугаман хамаарлын хүчийг илэрхийлнэ. R-ийн утга -1 ≤ R ≤ +1 хооронд хэлбэлзэнэ. R ойролцоогоор 0 → хамаарал сул буюу байхгүй, R эерэг (+) → хувьсагчид хоорондоо зэрэг өсдөг, R сөрөг (–) → нэг нь өсөхөд нөгөө нь буурдаг, R 1 буюу -1-т ойртох тусам → маш хүчтэй хамаарал байна.

[4] R Square нь хамааралтай хувьсагчийн өөрчлөлтийн хэдэн хувийг тухайн регрессийн модель (орсон бие даасан хувьсагчид) тайлбарлаж чадаж байгааг харуулна. R² бага (0.1-аас доош) бол → моделийн тайлбарлах хүч сул, R² дунд зэрэг (0.3–0.5) бол → боломжийн, R² өндөр (0.7-аас дээш) бол → маш сайн тайлбарлагч модель гэж үздэг (гэхдээ салбар бүрт шалгуур өөр).

[5] Sig. (p-value) нь регрессийн модель бүхэлдээ утга бүхий эсэхийг шалгаж өгдөг үзүүлэлт юм. p < 0.05 Модель бүхэлдээ статистикийн хувьд утга бүхий буюу статистикийн хувьд ач холбогдолтой. p ≥ 0.05 → Модель утга бүхий биш буюу статистикийн хувьд ач холбогдолгүй.

УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал, УИХ-ын хууль санаачлах болон хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал, УИХ-ын гишүүний чиг үүрэг, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын иргэдийн үнэлгээ зэрэг 5 үзүүлэлтийг харьцуулж, УИХ-ын үнэлгээнд нөлөөлөх нөлөөллийг харахад, УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдлын дундаж үнэлгээ бусад үзүүлэлттэй харьцуулахад статистикийн хувьд ач холбогдол маш бага байна. Харин УИХ-ын хууль санаачлах болон хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал, УИХ-ын гишүүний чиг үүрэг, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын иргэдийн үнэлгээ нь УИХ-ын үнэлгээнд эерэг хамааралтай буюу ач холбоогдолтой байна.

Coefficients[a]

Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	**.029**	.012		2.527	.012
	1. УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал	**.045**	.024	.041	1.864	.063
	2. УИХ-ын хууль санаачлах чиг үүрэг	**.084**	.028	.076	2.963	**.003**
	3. УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг	**.183**	.036	.134	5.108	**.000**
	4. УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүрэг	**.367**	.029	.328	12.841	**.000**
	5. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал	**.201**	.033	.153	6.082	**.000**

a. Dependent Variable: УИХ-ын үнэлгээ

Мөн дээрх 5 үзүүлэлт тус бүр дэх үнэлгээ нэг нэгжээр өсөхөд УИХ-ын үнэлгээ харилцан адилгүй дүнгээр нэмэгдэх боломжтой. Өөрөөр хэлбэл, УИХ-ын үнэлгээг нэмэгдүүлэхэд хамгийн гол хүчин зүйл нь гишүүдийн төлөөллийн чиг үүрэг бөгөөд дараагаар нь нийгэм, эдийн засгийн нөхцөл, УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргүүд чухал байна. Тодруулбал:

- ✓ Хамгийн хүчтэй нөлөөтэй хувьсагч нь УИХ-ын гишүүдийн төлөөллийн чиг үүрэг;
- ✓ Дараах хүчтэй нөлөөлөгчид: Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал болон УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг;
- ✓ Бага нөлөөтэй боловч ач холбогдолтой хувьсагч: УИХ-ын хууль санаачлах чиг үүрэг;
- ✓ Ач холбогдол маш бага хувьсагч: УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал байна.

Томъёо

***Y** = Constant + (B1 * X1) + (B2 * X2) + (B3 * X3) + (B3 * X4)*

- ***Y** = УИХ-ын үнэлгээ*
- ***Constant** = Бүх хувьсагчийн утга = 0 байх тохиолдлын суурь үнэлгээ*
- $B_1 \ldots B_n$ *= Тухайн хувьсагчийн оноо 1 оноогоор нэмэгдэхэд нэмэгдэх функт*
- $X_1 \ldots X_n$ *= тухайн хувьсагчийн дундаж оноо*

УИХ-ын үнэлгээ = 0.029 + (0.045 * 2.4) + (0.084* 2.6) + (0.183* 2.5) + (0.367* 2.5) + (0.201* 2.4) = 2.2

		B	X	B * X
	(Constant)	**0.029**		**0.029**
X буюу хувьсагч	1. УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй эсэх	**0.045**	**2.4**	0.110
	2. УИХ-ын хууль санаачлах чиг үүрэг	**0.084**	**2.6**	0.216
	3. УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг	**0.183**	**2.5**	0.456
	4. УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүрэг	**0.367**	**2.5**	0.905
	5. Эдийн засгийн нөхцөл байдал	**0.201**	**2.4**	0.482
Нийт				**2.2**

УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээнд нөлөөлөгч 5 хувьсагчийн үнэлгээний оноо хамгийн бага буюу 0 байхад одоогийн УИХ-ын үнэлгээ 0.029 байна.

*Дээрх хүснэгийн X баганад хувьсагч бүрийн дундаж оноог харуулсан. Иргэдийн өгсөн дундаж оноог (X1=2.4, X2=2.6, X3=2.5, X4=2.5, X5=2.4) B буюу регрессийн коэффициентуудтай үржүүлэн тооцоход **УИХ-ын таамагласан үнэлгээ ≈ 2.2** болж гарсан.*

*Энэ нь 1–5 онооны үнэлгээний хувьд **дунджаас доогуур**, буюу иргэдийн ерөнхий үнэлгээ сул байгааг илтгэж байна.*

1.4 Одоогийн УИХ-аас хүлээж буй иргэдийн хүлээлт

Фокус бүлгийн ярилцлагын хүрээнд судалгаанд оролцогчдоос "одоогийн УИХ-аас иргэдийн хүлээж буй хүлээлт ямар байгаа вэ?" гэж асуухад ерөнхийдөө иргэдийн амьдралд мэдэгдэхүйц өөрчлөлт авчрахуйц шударга, авлигагүй, бодит шийдвэртэй парламентыг бий болгох хэрэгтэй гэж үзэж байна. Тодруулбал:

- ✓ ***Үндэсний хөгжил, шударга ёс:** Улс орны ирээдүйг бодсон, чанартай шийдвэр гаргах, хууль тогтоомжийг зөвхөн ард иргэдийн эрх ашгийн төлөө зөөвөр батлах, хувийн хэвшлийг дэмжих хууль хэрэгтэй;*

- ✓ ***Амьдралын чанар, эдийн засаг:*** *иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, үнийн өсөлтийг хянах, цалин, тэтгэвэр нэмэх, тэтгэврийн зээлийн дараатыг бууруулах;*
- ✓ ***Авлига, хээл хахуультай тэмцэх:*** *Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангаж, авлигагүй болох. Эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын авлига, албан тушаалын хэрэгт зөвхөн торгууль тавьж өнгөрөөхөөс илүүтэй тохирсон хариуцлагыг хүлээлгэж хэвших;*
- ✓ ***Нийгмийн салбарын дэмжлэг:*** *Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлж, эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ЕБС-ийн ачааллыг бууруулж, сургууль, эмнэлгийн байр нэмж барих, их дээд сургуулийн төлбөрийн хөнгөлөлтийг зорилтот бүлэгт тэгш хүртээмжтэй хүргэх хэрэгтэй гэж үзэж байна.*

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАЖ БУЙ БАЙДАЛ

УИХ-ын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж буй эсэхийг хэмжихдээ, УИХ-ын гишүүнд үйл ажиллагаагаа иргэдэд тайлагнах, санал хүсэлтийг сонсох, мэдээллийн эх сурвалжуудаар дамжуулан мэдээлэл өгөх замаар УИХ-ын үйл ажиллагааны талаарх ойлголт мэдлэг ойлголт нь хэр байгааг харгалзсан.

УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй эсэхийг График 2-т харуулсан 5 асуултаар үнэлүүлэхэд дундаж хэрэгжилт 2.4 гарсан.

Эдгээр 5 үзүүлэлтээс иргэд олон нийт УИХ-ны үйл ажиллагааны талаарх мэдээллийг авдаг байдал болон УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдлэг ойлголтоо үнэлсэн нь дунджаас өндөр байгаа бол УИХ-ын чиг үүргийн талаарх мэдлэг, УИХ-ын гишүүний ажлаа сонгогчдод тайлагнах байдал, УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэх боломж зэрэг үзүүлэлт дунджаас бага байна.

Үүнээс онцлоход УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хамгийн их авдаг боловч, УИХ-ын үндсэн чиг үүргийн талаарх иргэд, олон нийтийн ойлголт мэдлэг хамгийн бага байна.

График 6. УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал




Тайлбар: *Маш сайн бол 5, маш муу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Иргэд УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг болохыг тодруулж, 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 3 гарсан. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 22% буюу ойролцоогоор 5 хүн тутмын нэг нь УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авдаг бол 56% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 6 нь хааяа мэдээлэл авдаг байна. Энэ нь иргэдийн 78% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 8 нь ямар нэг байдлаар УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авдаг болохыг харуулж байна.

Харин 21% буюу ойролцоогоор 5 хүн тутмын нэг нь УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авдаггүй байна.

График 7. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ?

Дундаж үнэлгээ: 3



Тайлбар: *Байнга мэдээлэл авдаг бол 5, огт мэдээлэл авдаггүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авдаг эсэх дүнг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харвал, бүх бүлэгт ялгаатай нөхцөл байдал илэрч байна.

Хүснэгт 10. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[6]
Оршин суугаа газар	**0.016**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.003**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.000**
Боловсролын түвшин	**0.004**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.036**
Амьжиргаа	**0.003**


[6] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг болохыг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

Бага зэргийн ялгаатай байдлыг харвал, аймаг орон нутагт, тэр дундаа сумын төв, хөдөө амьдардаг, 45-аас дээш насны, эрэгтэй, тусгай дундаас дээш боловсролтой, тэтгэвэр группт байдаг, өрхийн дундаж орлого нь 400,000-аас 1,800,000 төгрөг, амьжиргааны хувьд орлого нь хоол хүнс болон хувцас хунар авахад хүрэлцдэггүй, мөн санхүүгийн асуудалгүй хүмүүс илүү УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авдаг байна.

Нөгөө талаас, УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг арай бага авдаг нийгмийн бүлгийг төв суурин газар болох Улаанбаатар хот болон аймгийн төвд амьдардаг, 44 хүртэлх насны, эмэгтэй, бүрэн дунд боловсролтой, хувийн хэвшилд ажилладаг, оюутан сурагч, цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй, өрхийн дундаж орлого нь 1,800,000-аас дээш, орлого нь амьдралын наад захын хэрэглээ буюу хоол, хувцас хунараа авахад хүрэлцдэг ч цахилгаан хэрэгсэл, машин, байр орон сууц авахад хүрэлцдэггүй хүмүүс бүрдүүлж байна.

График 8. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)



Фокус бүлгийн ярилцлагаар УИХ-ын үйл ажиллагааг яагаад сонирхдог, эсвэл яагаад сонирхдоггүй болохыг тодруулахад дараах шалтгаан илэрч байн. Үүнд:

- ✓ *УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонирхож харж буй шалтгааныг тодруулахад, төрийн албан болон боловсрол өндөртэй хүмүүс хууль тогтоомж, шийдвэрүүд нь өөрсдийн ажил мэргэжил, амьдралтай нягт холбоотой гэж үздэг. Харин тэтгэврийн ахимаг насныхны хувьд төрийн бодлого шийдвэр нь тэдний амьдралд нөлөөлөхөөс гадна чөлөөт цагийн хэрэглээний нэг хэлбэр нь болдог байна. Тэгвэл нийгмийн идэвхтэй байр суурьтай хүмүүсийн хувьд УИХ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ухаж, сонирхох дуртай байдаг аж.*
- ✓ *Харин УИХ-ын үйл ажиллагааг төдийлөн сонирхохгүй байгаа шалтгааныг тодруулахад, УИХ-ын гишүүдийн хуралдаанд оролцох ирц, оролцоо сул, гаргасан шийдвэр нь иргэдийн өдөр тутмын амьдралд шууд үр дүн өгдөггүй тул итгэл нь алдарсан. Мөн гишүүд ажилдаа хариуцлагагүй ханддаг, өөрсдөдөө хэрэгтэй асуудалд идэвхтэй байр суурьтай байдаг гэж шүүмжлэлтэй байр суурийг илэрхийлж байна.*
  Нөгөө талаар зарим иргэд ажил, амьдралын асуудлаа нэн тэргүүнд тавьж, УИХ-ын үйл ажиллагааны мэдээлэл өөрсдөд нь тийм ч чухал биш, хааяа хэвлэл мэдээллийн хэрэгслээр санамсаргүй байдлаар мэдээлэл авдаг гэжээ.

УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авдаг эх сурвалжийг тодруулахад судалгаанд оролцогчид давхардсан тоогоор 3,071 эх сурвалжийг нэрлэсэн. Тус дүнг 100%-д шилжүүлж, мэдээллийн эх сурвалжийн хүртээмжийг харвал 38% нь фэйсбүүк, 33% нь телевизээс мэдээлэл авдаг буюу дийлэнх жинг эзэлж байна.

Харин олон сонголтын зарчмаар тус асуултын хариултын дүнг уншвал, иргэдийн 77% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 8 нь фэйсбүүк, 66% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 7 нь телевизээс мэдээлэл авдаг гэжээ.

График 9. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?



УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн авдаг мэдээллийн эх сурвалжийг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харвал фэйсбүүкийн хэрэглээ 18-34 насныхан, телевизийн хэрэглээ 45-аас дээш насныхны дунд бусад насныхантай харьцуулахад өндөр байна. 18-24 насны залуучуудын хувьд фэйсбүүк, телевизээс гадна гэр бүлийн хүн, мэдээллийн сайт, “Х” буюу твиттер нэмэлт эх сурвалж болж байгаа нь бусад насныхантай харьцуулахад илүү байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 11. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ? (Насны бүлгээр)

	Ерөнхий	18-24 нас	25-34 нас	35-44 нас	45-54 нас	55-аас дээш
Фэйсбүүк	**77%**	**91%**	**92%**	85%	72%	50%
Телевиз	**66%**	47%	49%	64%	**79%**	**87%**
Мэдээллийн сайт	**17%**	**31%**	22%	21%	10%	6%
Найз нөхөд	**12%**	**11%**	10%	13%	14%	13%
Гэр бүлийн хүнээсээ (эхнэр нөхөр, ах дүү, ээж аав гэх мэт)	**8%**	**13%**	6%	7%	8%	6%
Ажлын хамт олон	**6%**	4%	8%	6%	8%	4%
Уулзалт, хэлэлцүүлэг	**2%**	1%	2%	1%	3%	5%
Бусад	**2%**	1%	3%	3%	2%	2%
Сонин, сэтгүүл	**2%**	2%	2%	1%	**3%**	**3%**
Тараах материал	**2%**	2%	1%	1%	2%	3%
“Х” буюу твиттер	**2%**	**4%**	**3%**	1%	-	1%

Радио	**2%**	-	-	3%	4%	4%
Мессеж	**0.5%**	-	-	1%	-	1%
Сургалтын үйл ажиллагаа	**-**	2%	-	-	-	-

Фокус бүлгийн ярилцлагын хүрээнд УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийн эх сурвалжийг тодруулахад цахим сүлжээ, тэр дундаа фэйсбүүкээс илүү мэдээлэл авдаг. Зарим тохиолдолд ikon.mn, gogo.mn мэдээллийн сайт мэдээллийн эх сурвалж нь болдог байна. Цахим сүлжээ буюу фэйсбүүкээс мэдээлэл авахдаа утсаа гүйлгэж байхдаа санамсаргүй байдлаар мэдээлэлд оногддог нь хурдан, хялбар мэдээлэл авах боломжийг бүрдүүлдэг. Нөгөө талаар найз нөхөдтэйгээ мэдээлэл хуваалцах, харилцаа тогтоох боломжтой байдаг нь давуу талтай гэж иргэдийн зүгээс үзэж байна.


Харин телевизээс УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч буй шалтгаан нь, бусад мэдээллийн эх сурвалж, тэр дундаа фэйсбүүкээр цацагдсан мэдээллээс найдвартай, баталгаатай гэж үздэг гэжээ.

Тэгэхээр УИХ-ын талаарх мэдээллийг иргэдэд хүргэхдээ ***цахим орчин дахь хүртээмж ба телевизийн итгэлцлийг хослуулах*** *нь үр дүнтэй гэж дүгнэж болохоор байна.*

Судалгаанд оролцогчдоос өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг болохыг тодруулж, 1-ээс 5 оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.7 гарсан. Тодруулбал, иргэдийн 10% нь өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг мэднэ гэж үзэж байгаа бол 53% буюу ойролцоогоор 2 хүн тутмын нэг нь дунд зэрэг, 34% буюу ойролцоогоор 3 хүн тутмын нэг нь мэдэхгүй гэж дүгнэжээ.

График 10. Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ?

Дундаж үнэлгээ: 2.7



Тайлбар: *Маш сайн мэдэх бол 5, огт мэдэхгүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдлэгээ хэрхэн үнэлж буйг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, нас, хүй, боловсрол, ажил эрхлэлт, өрхийн дундаж орлого, амьжиргааны түвшнээрээ ялгаатай байна.

Хүснэгт 12. Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[7]
Оршин суугаа газар	**0.173**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.859**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.000**
Боловсролын түвшин	**0.000**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.006**
Амьжиргаа	**0.003**


УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг болохыг судалгаанд оролцогчдоор өөрсдөөр үнэлүүлж, хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

Бага зэргийн ялгаатай байдлыг харвал, 44-өөс дээш настай, бүрэн бус дунд болон магистраас дээш боловсролтой, тэтгэвэр группийн болон малчид, өрхийн дундаж орлого нь 1,800,000 хүртэлх, амьжиргааны хувьд орлого нь хоол хүнснээс гадна хувцас авахад л хүрэлцдэг хүмүүс илүү өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааны талаар мэддэг гэж хариулсан байна.

Нөгөө талаас, УИХ-ын үйл ажиллагааг төдийлөн бага мэддэг гэж хариулсан нийгмийн бүлгийг 18-24 настай, эмэгтэй, бага сургуулийн болон бүрэн дундаас бакалаврын зэргийн боловсролтой, оюутан сурагч болон цалинтай хөдөлмөр эрхэлддэггүй, 1,800,001-ээс дээш орлоготой, орлого нь амьдралын наад захын хэрэглээ буюу хоол, хувцас хунараа авахад хүрэлцдэг ч цахилгаан хэрэгсэл, машин, байр орон сууц авахад хүрэлцдэггүй хүмүүс бүрдүүлж байна.

[7] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

График 11. Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)




Судалгаанд оролцогчдод хариултын хувилбарыг санал болгож, УИХ-ын чиг үүргийг сонгуулсан. Тус хариултаас зөв нь “Одоо мөрдөгдөж буй хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах, Засгийн газын үйл ажиллагаанд хяналт тавих, Шаардлагатай шинэ хуулийг санаачлах, Ард түмний засаглах эрхийг хангах, Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, бодлого, хууль тогтоомжид тусгах” гэсэн 5 хариулт байсан бөгөөд хамгийн дээд дүн 5 оноо, хамгийн бага нь 0 оноо байсан болно.

Судалгаанд оролцогчдын авсан оноог 100%-д шилжүүлэн харвал 28% нь (14% нь 5 оноо буюу бүх зөв хариултыг сонгосон бол 4% нь 4 оноо, 10% нь 3 оноо) буюу ойролцоогоор 3 хүн тутмын нэг нь 3-аас 5 оноо авч, УИХ-ын чиг үүргийн талаар дундаж ойлголт мэдлэгтэй байна. Харин 55% нь муу мэдлэгтэй (25% нь 2 оноо, 30% нь 1 оноо) байгаа бол 17% нь огт УИХ-ын чиг үүргийн талаар мэдлэггүй байна.

Харин олон сонголтын зарчмаар тус асуултын хариултын дүнг уншвал, хамгийн багадаа 3 хүн тутмын нэг нь УИХ-ын чиг үүргийн талаар тодорхой ойлголттой байгаа бол 36% буюу 3 хүн тутмын нэг нь гүйцэтгэх засаглалын чиг үүргийг хольж, сольж ойлгож байгаа нь харагдлаа.

Чиг үүрэг тус бүрээр харвал, “иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, бодлого, хууль тогтоомжид тусгах” гэсэн зөв хариултыг судалгаанд оролцогчдын 52% сонгосон нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бол удаах жин дарж байгаа зөв ойлголт нь “ард түмний засаглах эрхийг хангах”, “шаардлагатай шинэ хуулийг санаачлах” байна.

График 12. Та дараах хариултын хувилбаруудаас УИХ-ын чиг үүргийг сонгоно уу?



Тайлбар: *Хамгийн дээд оноо 5, огт зөв хариулаагүй бол 0, 0-ээс 5 хүртэлх оноогоор үнэлсэн.*

Фокус бүлгийн ярилцлагаар УИХ-ын чиг үүргийн талаарх ойлголтыг бататган асуухад “хууль санаачлах, батлах, нэмэлт өөрчлөлт оруулах”, “иргэдийн санал хүсэлтийг бодлого, хууль тогтоомжид тусгах”, “ард иргэдийн амьдралд чиглэсэн бодлого гаргах” зэрэг УИХ-ын чиг үүргийг зөв ойлгох тал руугаа хандсан боловч нийтлэг тодорхой бус байдал их байна. Тус хариултыг хэлж буй хүмүүс дунд дээд/бакалавраас дээш зэргийн боловсролтой хүмүүс жин дарж байна.

УИХ-ын чиг үүргийн талаар буруу, бүрхэг ойлголттой хүмүүс УИХ-ын чиг үүргийг татвар, тэтгэвэр, иргэдийн амьжиргааг шийдвэрлэх, УИХ бол хууль батлаад л дуусдаг гэх зэргээр тайлбарлах хандлага байна. Тус хүмүүсийн нийгмийн бүлгийн онцлог нь 18-24 хүртэлх насны залуучууд, болон ахмадууд байсан болно.


Харин УИХ-ын чиг үүргийн талаар мэдэхгүй, ойлгодоггүй гэх бүлэг бага болон бүрэн бус дунд боловсролтой иргэдийн дунд давамгайлж байлаа.

График 12-т дурдсанчлан УИХ нь иргэдийн санал хүсэлтийг бодлого, хууль тогтоомжид тусгах чиг үүрэгтэй бөгөөд тус ажлынхаа үндсэн дээр УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнаж байх үүрэгтэй билээ.

Тэгвэл судалгаанд оролцогчдоос “Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу?” гэж асууж, 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.3 гарсан бол 22% буюу 5 хүн тутмын нэг нь тус асуултад хариулж мэдэхгүй байсан болно. Тодруулбал, иргэдийн 21% нь буюу ойролцоогоор 5 хүн тутмын нэг нь тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд ажлаа ямар нэг байдлаар тайлагнадаг гэж хариулсан бол 47% нь буюу ойролцоогоор 2 хүн тутмын нэг нь үгүй гэж хариулсан байна.

График 13. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу?

Дундаж үнэлгээ: 2.3



Тайлбар: *Маш сайн бол 5, огт үгүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг эсэхэд хариулсан дүнг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харвал, оршин суугаа газар, хүйс, боловсрол, ажил эрхлэлт, амьжиргааны хувьд ялгаатай байдал илэрсэн.

Хүснэгт 13. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[8]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.556**
Насны бүлэг	**0.150**
Хүйс	**0.017**
Боловсролын түвшин	**0.001**
Ажил эрхлэлт	**0.001**
Өрхийн дундаж орлого	**0.079**
Амьжиргаа	**0.007**


Тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? Гэсэн асуулт дахь хариултын дүнг хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

Бага зэргийн ялгаатай байдлыг харвал, аймаг, орон нутагт амьдардаг, эмэгтэй, бага сургуулийн боловсролтой, оюутан сурагч болон малчин, амьжиргааны хувьд орлого нь машин байр авах зэрэг асуудлаас гадна бусад хэрэгцээнд хүрэлцдэг гэх хүмүүс тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг гэж хариулсан нь бусдаас өндөр байна.

Нөгөө талаас, тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнах байдал бага гэж хариулсан нийгмийн бүлгийг 18-24 настай, эрэгтэй, магистраас дээш зэргийн боловсролтой, цалинтай хөдөлмөр эрхэлддэггүй, орлого нь амьдралын наад захын хэрэглээ буюу хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй хүмүүс бүрдүүлж байна.

[8] Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.

График 14. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)




Судалгаанд оролцогчдын 72% хувь нь УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлж байгаагүй бол 28% хувь ямар нэг байдлаар санал бодлоо илэрхийлж байжээ.

Санал бодлоо илэрхийлж байсан хүмүүс болох 29%-ийг 100% гэж үзэж, дундаж үнэлгээг гаргахад 2.2 гарсан. Өөрөөр хэлбэл санал бодлоо илэрхийлж байсан хүмүүсийн 69% нь хэцүү, 17% нь дунд зэрэг, 14% нь хялбархан байсан гэж хариулсан байна.

График 15. Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу?

Дундаж үнэлгээ: 2.2



Тайлбар: *Маш хялбар бол 5, маш хэцүү бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа санал бодлоо илэрхийлж байгаагүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

УИХ-ын гишүүнд ямар нэг байдлаар санал хүсэлтээ илэрхийлж байсан хүмүүсийн дүнг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харвал, аймаг, орон нутагт оршин суугаа байршил, боловсрол, амьжиргааны хувьд ялгаатай байдал илэрсэн.

Хүснэгт 14. Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[9]
Оршин суугаа газар	**0.157**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.031**
Насны бүлэг	**0.534**
Хүйс	**0.743**
Боловсролын түвшин	**0.004**
Ажил эрхлэлт	**0.851**
Өрхийн дундаж орлого	**0.991**
Амьжиргаа	**0.030**

УИХ-ын гишүүнд ямар нэг байдлаар санал хүсэлтээ илэрхийлж байсан хүмүүс хялбар байсан эсэхийг үнэлүүлж, хариултын дүнг хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

Бага зэргийн ялгаатай байдлыг харвал, сумын төвд амьдардаг, бага болон бүрэн бус дунд боловсролтой, амьжиргааны хувьд хөргөгч, зурагт мэтийн гэр ахуйн зүйлээ худалдан авах боломжтой өрхийн гишүүд УИХ-ын гишүүнд санал бодлоо илэрхийлэхэд бусадтай харьцуулахад арай хялбар байсан гэж хариулсан.

Нөгөө талаас, УИХ-ын гишүүнд санал бодлоо илэрхийлэхэд хэцүү байсан гэх нийгмийн бүлэгт хөдөө амьдардаг, тусгай дунд боловсролтой, хоол хүнс, хувцас хунар зэрэг анхан шатны хэрэгцээгээ хангаад хөргөгч зэрэг зүйлс худалдан авах боломжгүй хүмүүс бүрдүүлж байна.

[9] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

График 16. Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)





График 15-д харуулсанчлан судалгаанд оролцогчдын 28% нь ямар нэг байдлаар УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлж байсан.

Санал хүсэлтээ илэрхийлсэн хэлбэрийг 100%-д шилжүүлж харахад 34% нь хурал, уулзалт дээр, 21% нь фэйсбүүк дээр сэтгэгдэл бичиж, 13% нь бичгээр, 9% нь жагсаал цуглаанд оролцож байсан бол Улсын Их Хурлын үндсэн үйл ажиллагаа болох хууль тогтоох үйл хэрэгт иргэд, олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн “My D-Parliament” цахим системээр дамжуулж санал хүсэлтээ илэрхийлж байсан дүн 6% байна.

Харин олон сонголтын зарчмаар тус асуултын хариултын дүнг уншвал, УИХ-ын гишүүнд санал бодлоо илэрхийлж байсан (28%) хүмүүсийн 47% нь хурал уулзалт дээр, 29% нь фэйсбүүк дээр сэтгэгдэл бичих, 18% нь бичгээр, 12% нь жагсаал цуглаанд оролцож байсан бол 9% нь Улсын Их Хурлын үндсэн үйл ажиллагаа болох хууль тогтоох үйл хэрэгт иргэд, олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн “My D-Parliament” цахим системээр дамжуулж санал хүсэлтээ илэрхийлж байжээ.

График 17. Та ямар хэлбэрээр УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлж байсан бэ?



Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос "иргэд, олон нийтэд УИХ, УИХ-ын гишүүдэд ямар хэлбэрээр санал бодлоо илэрхийлэх боломж байдаг уу?" гэж асуухад дийлэнх нь боломжгүй, санал бодлоо илэрхийлэх суваг байгаа ч хүлээж авдаггүй, хүлээж авсан ч бодитой үр дүн гардаггүй гэж хариулсан.

Харин УИХ, УИХ-ын гишүүнд санал бодлоо илэрхийлэх үр дүнтэй эх сурвалжийг дурдахдаа,

- *Иргэдтэй нүүр тулж уулзаж (хурал цуглаан зарлаж уулзах, уулзалт товлох, санал сонсдог өдөртэй болох) санал, хүсэлтийг сонсож, хэлэлцүүлэг зохион байгуулах нь ач холбогдолтой.*
- *Мөн цахим орчинд, нийгмийн сүлжээнд санал бодлоо илэрхийлэх, захидал бичих, албан ёсны и-мэйлээр илгээх гэх мэт орчин үеийн сувгийг ашиглаж*


иргэдийн санал хүсэлтийг УИХ, УИХ-ын гишүүд авах нь илүү үр дүнтэй гэсэн.

Гурав. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ САНААЧЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

УИХ хууль санаачлах чиг үүргээ хэрхэн хангаж буйг үнэлүүлэхдээ УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь уншихад ойлгомжтой байж, дагалдах дүрэм, журмын уялдаатай байдлыг хангаж, Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашгийг хамгаалж, улс орны хөгжилд эерэг өөрчлөлтийг авчирч чадаж байгаа эсэх талаарх иргэдийн үнэлгээнд тулгуурлаж гаргасан.

УИХ-ын хууль санаачлах чиг үүргийн дундаж үнэлгээ 2.6 гарсан. Тус үзүүлэлтийг бүрдүүлж буй 3 чиг үүргийг харвал, Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг гэж дундаж үзүүлэлт хамгийн өндөр байгаа бол хууль тогтоомжийн уялдаатай байдал, Үндэсний язгуур эрх ашиг, Монгол Улсын тусгаар тогтнол, эх орны хөгжилд нийцэж байгаа эсэх үнэлгээ дунджаас бага байна.

График 18. УИХ-ын хууль санаачлах чиг үүрэгт өгсөн иргэдийн үнэлгээ




Тайлбар: *Маш сайн бол 5, маш муу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? Гэж иргэдээс асууж 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.5 гарсан. Тодруулбал, тус асуултад нийцэж байна гэж судалгаанд оролцогчдын 10%, дунд зэрэг гэж 36%, нийцэхгүй байна гэж 45% нь хариулжээ.

График 19. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ?

Дундаж үнэлгээ: 2.5



Тайлбар: *Бүрэн нийцэж байгаа бол 5, огт нийцэхгүй байгаа бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа санал бодлоо илэрхийлж байгаагүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? Гэсэн асуултад хариулсан дүнг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харвал, оршин суугаа газар, насны бүлэг, хүйс, ажил эрхлэлтийн хувьд ялгаатай байдал илэрсэн.

Хүснэгт 15. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[10]
Оршин суугаа газар	**0.017**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.440**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.002**
Боловсролын түвшин	**0.051**

[10] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*


Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.555**
Амьжиргаа	**0.159**

УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд нийцэж байгаа эсэхийг үнэлүүлж, хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

Бага зэргийн ялгаатай байдлыг харвал, аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 настай, эрэгтэй, төрийн албанд ажилладаг болон оюутан сурагчид эерэг хариулт өгсөн нь бусадтай харьцуулахад өндөр байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн бүлгийг Улаанбаатар хотод амьдардаг, 35-аас дээш настай, эмэгтэй, хувийн хэвшилд ажилладаг, тэтгэвэр группийн, цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй хүмүүс нь илүү бүрдүүлж байна.

График 20. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)




Фокус бүлгийн ярилцлагаар Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? Гэсэн асуултад ямар байр суурьтай байгааг тодруулахад иргэдийн олонх нь хууль тогтоомжийг үндэсний эрх ашигт нийцэхгүй, иргэдийн бодит амьдралд хэрэгжихгүй гэж үзэж байна. Иймхүү дүгнэх үндэслэлийг харвал:

- ✓ *Гаднын улсын, тэр дундаа урд хөрш болох БНХАУ-ын нөлөөлөл их байгаа нь наадмын нээлтийг Хятад хүрээр хийлгэсэн, Хятадууд олноор Монгол Улсад орж ирж байгаагаас харж болно;*
- ✓ *Гаднын улсад байгалийн баялаг, уул уурхайгаа ашиглуулж, нөхөн сэргээхгүй байна;*
- ✓ *Иргэдийн амьдрал өдөр ирэх тусам доройтож байгаа нь хууль иргэдийн эрх ашигт нийцэхгүй байгааг харуулж байна гэжээ.*

Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чадаж байгаа эсэхийг үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.3 гарсан. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогчдын 8% нь тийм, 28% нь дунд зэрэг, 55% нь үгүй гэж хариулжээ.

График 21. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу?

Дундаж үнэлгээ: 2.3



Тайлбар: *Хангалттай бол 5, огт үгүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад оршин суугаа газар, насны бүлэг, хүйс, ажил эрхлэлт, амьжиргааны хувьд ялгаатай үзүүлэлт гарсан.

Хүснэгт 16. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[11]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.714**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.006**
Боловсролын түвшин	**0.448**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.071**
Амьжиргаа	**0.000**


Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг эсэхийг үнэлүүлж, хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

Бага зэргийн ялгаатай байдлыг харвал, аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 настай, эмэгтэй, төрийн албанд ажилладаг, оюутан сурагч болон малчин, өрхийн орлого нь амьжиргаанд хүрэлцээтэй хүмүүс эерэг хариулт өгсөн нь бусадтай харьцуулахад өндөр байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн нь Улаанбаатар хотод амьдардаг, 55-аас дээш настай, эмэгтэй, тэтгэвэр группийн, өрхийн орлого нь хоол, хувцас хунараа авч чадах хэмжээний амьжиргаатай хүмүүс нь бусадтай харьцуулахад илүү байна.

[11] Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.

График 22. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)




Монгол Улсын хууль, тогтоомж хэн бүхэн ойлгомжтой хэлбэрээр бичигдсэн байдаг эсэхийг үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 3.1 гарсан. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 32% нь ойлгомжтой, 28% нь дунд зэрэг, 24% нь ойлгомжгүй гэж хариулжээ.

Мөн 17% нь ямар нэг байдлаар хууль, тогтоомж уншиж байгаагүй бөгөөд тус асуултад хариулж мэдэхгүй гэж хариулсан байна.

График 23. Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу?

Дундаж үнэлгээ: 3.1



Тайлбар: *Хангалттай бол 5, огт үгүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад оршин суугаа газар, насны бүлэг, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлт, өрхийн дундаж орлого, амьжиргааны хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 17. ***Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу?*** **(Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)**

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[12]
Оршин суугаа газар	**0.006**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.557**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.038**
Боловсролын түвшин	**0.008**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.039**
Амьжиргаа	**0.000**


[12] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг эсэхийг үнэлүүлж, хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

Бага зэргийн ялгаатай байдлыг харвал, аймаг, орон нутагт амьдардаг, 34 хүртэлх насны, эрэгтэй, бүрэн дунд болон бакалаврын зэргийн боловсролтой, төрийн албанд ажилладаг, оюутан сурагч, 1,200,000-аас дээш өрхийн орлоготой, ямар нэг санхүүгийн асуудалгүй хүмүүс Монголын хууль, тогтоомж уншихад ойлгомжтой гэж үзэж буй нь бусадтай харьцуулахад өндөр байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн нийгмийн бүлгийн ялгааг харвал, Улаанбаатар хотод амьдардаг, 55-аас дээш настай, эмэгтэй, бүрэн бус дунд болон магистраас дээш зэргийг боловсролтой, хувийн хэвшилд ажилладаг, тэтгэвэр группийн, цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй, амьжиргааны хувьд орлого нь хоол хүнс, хувцас хунар зэрэг амьдралын наад захын хэрэгцээгээ хангаж чаддаггүй хүмүүс жин дарж байна.

График 24. Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)




Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

УИХ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж чадаж буй эсэхийг хэмжихдээ, хууль тогтоомж нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд үзүүлэх нөлөөлөл, хэрэгжүүлэгч байгууллага болох төрийн байгууллагын үйлчилгээний нөхцөл байдал, хууль тогтоомж урт хугацаанд болон нийгэмд шинээр үүсэж асуудлыг зохицуулж, хүн бүрд тэгш үйлчилж байгаа эсэхийг харгалзсан.

УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг дараах 6 үзүүлэлтийн дунджаар гаргахад 2.5 гарсан. Дунджаас өндөр буюу хэрэгжилт бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн өндөр байгаа төрийн байгууллагын үйлчилгээ, аливаа асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх боломж байна. Харин хамгийн бага үнэлгээ авсан нь аливаа хуулиар шийдвэрлэх асуудал гарахад хүн бүрд хуулийн дагуу эрх тэгш хандах зарчим алдагдаж, танил талтай хүний талд шийдвэр гаргах нөхцөл бүрдсэн тухай асуудал байлаа.

Мөн УИХ-аас батлан гаргаж буй хуулийн иргэдэд тулгамдсан асуудлыг зохицуулах, улс оронд хөгжил авчрах чиг үүргийн хэрэгжилт дунджаас бага зэрэг муу байсан бөгөөд хууль хэрэгжихдээ урт хугацаанд тогтвортой үйлчлэх мөн чанар алдагдсан гэж иргэж үзэж байна.

График 25. УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ




Тайлбар: *Маш сайн бол 5, маш муу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Иргэд өдөр тутамдаа өөрт тулгарсан, шийдвэрлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагаас чөлөөтэй үйлчилгээ авах эрхтэй.

Тэгвэл тус эрх нь хангагдаж буй эсэхийг тодруулж, үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 3.2 гарсан. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагаас үйлчилгээ авахад эрх нь зөрчигдөөгүй гэж судалгаанд оролцогчдын 32%, дунд зэрэг гэж 11%, эрх нь зөрчигдсөн гэж 27% нь хариулсан.

График 26. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү?

Дундаж үнэлгээ: 3.2



Тайлбар: *Маш сайн бол 5, маш муу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа төрийн байгууллагаас үйлчилгээ аваагүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад оршин суугаа газар, насны бүлэг, боловсролын түвшин, ажил эрхлэлт, өрхийн дундаж орлогын хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 18. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[13]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.209**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.034**
Боловсролын түвшин	**0.001**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.002**
Амьжиргаа	**0.104**


[13] Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.

Иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл учирдаг эсэхийг үнэлүүлж, хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

Төрийн байгууллагаас үйлчилгээ авахад бусадтай харьцуулахад хүндрэл бага мэдэрдэг гэж хариулсан дүн аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 нас, 55-аас дээш насны, бүрэн дунд хүртэлх боловсролтой, оюутан сурагч, тэтгэвэр группийн, цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй болон малчид, 1,200,000 төгрөг хүртэлх орлоготой хүмүүсийн дунд өндөр байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу төрийн үйлчилгээг авахад хүндрэлтэй байдаг гэж үзэж буй нийгмийн бүлэгт Улаанбаатар хотод амьдардаг, 25-44 настай хөдөлмөрийн насны, бакалавраас дээш зэргийн боловсролтой, төрийн болон хувийн хэвшилд ажилладаг, 2,500,000-аас дээш орлоготой иргэд жин дарж байна.

График 27. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)



Төрийн байгууллагаас үйлчилгээ авахад эрх нь зөрчигдсөн мэт мэдрэмж төрсөн гэж судалгаанд оролцогчдын 27% буюу ойролцоогоор 4 хүн тутмын нэг нь хариулсан. Эдгээр хүмүүсээс хаанаас, ямар үйлчилгээ авахад эрх нь зөрчигдсөн болохыг тодруулахад 410 хүн давхардсан тоогоор 669 мэдээлэл өгсөн.

Тус дүнг 100%-д шилжүүлж, асуудлыг харвал, эрүүл мэндийн үйлчилгээтэй хамааралтай асуудал 39%-ийг эзэлж байгаа бол удаах нь төрийн байгууллагын үйлчилгээтэй холбоотой асуудал 20% байна. Мөн цагдаа, шүүхийн байгууллагатай холбоотой асуудал 13%, газрын маргаантай холбоотой асуудал 6.3%, нийгмийн халамж, татварын байгууллагатай холбоотой асуудал 9%, боловсролын байгууллагатай холбоотой асуудал 4%-ийг эзэлж байна.

Хүснэгт 19. Хаанаас үйлчилгээ авахад ямар хэлбэрээр эрх тань зөрчигдсөн бэ?

№	Тохиолдол	Хувь	№	Тохиолдол	Хувь
1	Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд эрх зөрчигдөж байгаа мэт санагдсан	20%	19	Боловсролын салбарын үйлчилгээ муу	1%
2	Төрийн байгууллага харилцаа, үйлчилгээ муу	13%	20	Газрын алба өмчлөх, шилжүүлэх эрх шийдэж өгдөггүй	1%
3	Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээ, харилцаа хандлага муу	7%	21	Улсын бүртгэлийн ерөнхий газар	1%
4	Цагдаагийн байгууллага үйлчилгээний чанар муу	7%	22	Шүүх хэргийг буруу шийдвэрлэсэн	1%
5	Эрүүл мэндийн үйлчилгээ авахад цаг хугацаа их ордог	6%	23	Банкны харилцаа, үйлчилгээ муу	1%
6	Татвар, НДШ өндөр	4%	24	Төрийн байгууллагаас бичиг баримт авахад хүндрэлтэй	1%
7	Газрын албаныхан харилцаа, үйлчилгээ муу	4%	25	Сан, ЖДҮ ээс зээл авахад хүндрэлтэй	1%
8	Дүүрэг, хороодын үйлчилгээний чанар муу	3%	26	Цагдаа, шүүх аврига, ашиг сонирхлын зөрчилдөөн	1%
9	Нийгмийн даатгалын харилцаа үйлчилгээ муу	3%	27	Сургуульд ороход хүндрэлтэй, авлигал, ашиг сонирхлын зөрчилдөөнтэй	1%
10	Эрүүл мэндийн байгууллага мөнгө санхүүгийн асуудал	3%	28	Гааль байгууллага хүндрэлтэй, авлигал, ашиг сонирхлын зөрчилдөөнтэй	1%
11	Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж хомс	2%	29	Банкны зээлийн хүү, шаардлага өндөр	1%
12	Нэг цонхны үйлчилгээний чанар муу	2%	30	Цахилгааны үнэ өндөр	1%
13	Шүүхийн байгууллагаар үйлчлүүлэхэд эрх зөрчигдөж байгаа мэт санагдсан	2%	31	Цагдаагийн харилцаа муу	0.3%
14	НД тэтгэвэр, тэтгэмжийн асуудал шийдвэрлэхэд хүндрэлтэй	2%	32	Газрын алба ашиглах боломжгүй газар өгдөг	0.3%
15	Сургуулийн харилцаа, үйлчилгээ муу	2%	33	1111 гомдол шийдвэрлэдэггүй, алга болдог	0.3%
16	Эрүүл мэндийн байгууллага эмчилгээний чанар	1%	34	Хөдөлмөрийн чадваргүй хүнийг группээс хассан	0.3%
17	Цагдаа хэрэг, зөрчлийг буруу шийдвэрлэсэн	1%	35	Ажлын байрны дарамт	0.3%

18	Газрын алба ажил удаашруулдаг, цаг хугацаа алддаг	**1%**	**36**	Сургалтын төлбөр өндөр	**0.1%**
			37	Бусад	**4%**
			Нийт		**100%**


Фокус бүлгийн ярилцлагын хүрээнд төрийн ямар байгууллагаас үйлчилгээ авахад ямар хэлбэрээр хүний эрх зөрчигдөж байгаа талаар тодруулахад, хүнд суртал, харилцааны доголдол, шударга бус байдалд хамгийн их гомдоллож, энэ нь тэдний эрүүл мэндийн эрх, шударга хандах эрх, мэдээлэл авах эрхийг зөрчиж байна гэж үзсэн. Тодруулбал:

- ✓ *Иргэдийн хамгийн их эрх нь зөрчигдсөн гэж үзсэн төрийн үйлчилгээ* ***нь эрүүл мэндийн үйлчилгээ****тэй холбоотой асуудал байсан. Тухайлбал эрүүл мэндийн үйлчилгээ авахад хүнд суртал, оочир дараалал, үйлчилгээний хүртээмж муу байдал тулгардаг. Жишээ нь, эрүүл мэндийн даатгал төлсөн ч зарим эмчилгээг хийхгүй, хувийн эмнэлэг рүү явуулдаг. Дийлэнх тохиолдолд шүдний эмчилгээг улсын эмнэлэгт хийдэггүй. Түргэн тусламж дуудахад удаан ирдэг зэрэг асуудлууд байсаар байна.*
- ✓ ***Цагдаа нарын харилцаа хандлага*** *бүдүүлэг, жирийн иргэнд дарамт үзүүлдэг, хариуцлагагүй, иргэн бүрд эрх тэгш ханддаггүй, танил тал, илүү мөнгөтэй хүний талд үйлчлэх асуудал нэг бус удаа гарсан зэрэг зөрчил илэрсэн.*
- ✓ ***Нийгмийн даатгал, татварын асуудал:*** *Нийгмийн даатгалын шимтгэл тодорхойгүй, татварын тооцоолол жирийн иргэдэд ойлгомжгүй, тодорхойгүй байдаг. Энэ агуулгаараа иргэдийн санхүүгийн эрхийн талаарх мэдээлэл авах, ойлгомжтой үйлчилгээгээр хангагдах эрх хангалтгүй байдаг.*

УИХ-аас баталж буй хуулиуд иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байгаа эсэхийг 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.3 гарсан. Тодруулбал, судалгаанд оролцогчдын УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чаддаг гэж судалгаанд оролцогчдын 6%, дунд зэрэг гэж 28%, чаддаггүй гэж 54% буюу ойролцоогоор 2 хүн тутмын нэг нь хариулсан.

График 28. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу?

Дундаж үнэлгээ: 2.3



Тайлбар: *Хангалттай бол 5, огт үгүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад оршин суугаа газар, насны бүлэг, боловсролын түвшин, ажил эрхлэлт, өрхийн дундаж орлого, амьжиргааны хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 20. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[14]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.498**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.369**
Боловсролын түвшин	**0.001**
Ажил эрхлэлт	**0.003**
Өрхийн дундаж орлого	**0.007**
Амьжиргаа	**0.001**

[14] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*


УИХ-аас баталж буй хуулиуд иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байгаа эсэхийг үнэлүүлж, хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

УИХ-аас баталж буй хуулиуд иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байгаа гэж хариулсан дүн бусадтай харьцуулахад өндөр гэж хариулсан нийгмийн бүлгийг харвал, аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 настай, бага сургуулийн болон магистраас дээш боловсролтой, оюутан сурагч болон малчин, 400,000-1,200,000 төгрөг, 2,500,000-аас дээш өрхийн орлоготой, орлого нь байр орон сууц авахад хүрэлцдэггүй хүмүүс байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу УИХ-аас баталж буй хуулиуд иргэдэд тулгамдсан асуудлыг зохицуулж чаддаггүй гэж үзэж буй нийгмийн бүлэгт Улаанбаатар хотод амьдардаг, 25-44 настай, тусгай дунд боловсролтой, хувийн хэвшилд ажилладаг, 1,800,000-аас дээш өрхийн орлоготой, орлого нь хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй иргэд жин дарж байна.

.

График 29. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)




Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос “Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу?” гэж асуухад, иргэдийн хүлээлт бол амьдралд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, шударга хэрэгждэг хуультай болох боловч одоогийн УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаа энэ шаардлагад нийцэхгүй байна гэж үзэж байна. Учир нь:

- ✓ *Хууль тогтоогч буюу гишүүдийн чадвар сул, хариуцлагагүй, баталсан хууль нь бодит амьдралд нийцдэггүй;*
- ✓ *Иргэдэд ашигтай гэхээс илүүтэй өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн хууль баталдаг;*
- ✓ *Хуулийн хэрэгжилт муу, хууль хүн бүрд эрх тэгш үйлчлэх ёстой байтал авлига, танил талаас үүдэн шударга үйлчилдэггүй;*
- ✓ *Иргэдэд хэрэгтэй хуулийн хэрэгжилт муу хэр нь татварын дарамт нэмэгдүүлж байна;*
- ✓ *Чанга дуутай машинтай холбоотой зохицуулалт зэрэг жижиг сажиг асуудлыг шийдвэрлэх тал дээр анхаардаг ч амьдралд хэрэгтэй хууль баталдаггүй;*
- ✓ *Байгалийн баялгийг ухаж, цөөн хүн хөлжиж байгаа ч иргэдэд тэгш хүртээмжтэй хүрч амьдралын чанарт нөлөөлдөггүй гэж үзэж байна.*

УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчирч чадаж байгаа эсэхийг 1-ээс 5 оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.4 гарсан. Тодруулбал, иргэдийн 9% нь тус асуултад тийм, 28% нь дунд зэрэг, 49% нь үгүй гэж хариулжээ. Харин 14% нь тус асуултад хариулж мэдэхгүй байна.

График 30. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу?

Дундаж үнэлгээ: 2.4



Тайлбар: *Хангалттай бол 5, огт үгүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад оршин суугаа газар, насны бүлэг, ажил эрхлэлт, амьжиргааны хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 21. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[15]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.808**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.135**
Боловсролын түвшин	**0.091**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.165**
Амьжиргаа	**0.006**


[15] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчирч чадаж байгаа эсэхийг үнэлүүлж, хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчирч чадаж байгаа гэсэн дүн бусадтай харьцуулахад өндөр гэж хариулсан нийгмийн бүлгийг харвал, аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 настай, оюутан сурагч болон малчин, орлого нь машин, орон сууц авахад хүрэлцдэггүй болон орлого нь хүрэлцээтэй хүмүүс байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчирч чадахгүй байна гэж үзэж буй нийгмийн бүлэгт Улаанбаатар хотод амьдардаг, 35-44 нас, 55-аас дээш насны, хувийн хэвшилд ажилладаг болон цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй, орлого нь хоол хүнсээ авахад хүрэлцдэггүй иргэд жин дарж байна.

График 31. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)



Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос "Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу?" гэж асуухад, дийлэнх нь чаддаггүй гэж хариулсан. Тодруулбал:


- ✓ *Чадахгүй байна гэж үзэж буй шалтгаан нь, татвар, үнийн өсөлт, инфляц нэмэгдэж, хууль тогтоомжийн эерэг нөлөөг арилгаж байна. Мөн байгалийн баялгийн ашиглалт муугаас нөхөн сэргээлтгүй уул уурхай, хүрээлэн буй орчны доройтол бий болж байна;*

- ✓ *Мөн хууль тогтоомжийг урт хугацааны бодлого, тогтвортой хөгжил авчирна гэдэгт итгэх итгэлгүй байгаагаа илэрхийлсэн;*
- ✓ *Цөөн хүн шинэ зам, барилга баригдаж, удаан гацсан томоохон төслүүдийг явуулж байгааг иш татаж, эерэг байр суурийг илэрхийлсэн.*

"Монголын хууль 3 хоног л үйлчилдэг" буй аливаа хууль батлагдсанаас хойш тогтвортой хэрэгжиж чаддаг эхийг 1-ээс 5 оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.2 гарсан. Тодруулбал "Монголын хууль 3 хоног л үйлчилдэг" гэсэн үгтэй судалгаанд оролцогчдын 67% санал нийлж, 12% нь дунд зэрэг, 16% нь санал нийлэхгүй байна гэж хариулжээ.

График 32. Та "Монголын хууль 3 хоног л үйлчилдэг" гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ?

Дундаж үнэлгээ: 2.2



Тайлбар: *Огт санал нийлэхгүй бол 5, бүрэн санал нийлж байгаа бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад насны бүлэг, хүйс, боловсрол, ажил эрхлэлт, амьжиргааны хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 22. **Та “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ?** ***(Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)***

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[16]
Оршин суугаа газар	**0.086**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.173**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.029**
Боловсролын түвшин	**0.017**
Ажил эрхлэлт	**0.003**
Өрхийн дундаж орлого	**0.205**
Амьжиргаа	**0.001**


“Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” буй аливаа хууль батлагдсанаас хойш тогтвортой хэрэгжиж чаддаг эхийг үнэлүүлж, хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

“Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй санал нийлэхгүй байгаа дүн бусадтай харьцуулахад өндөр нийгмийн бүлгийг харвал, 18-34 настай, эрэгтэй, бага сургуулийн болон магистраас дээш зэрэгтэй, оюутан сурагч, амьжиргааны хувьд ямар нэг санхүүгийн суудалгүй хүмүүс байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй санал нийлж буй нийгмийн бүлэгт 45-аас дээш настай, эмэгтэй, тусгай дунд боловсролтой, тэтгэвэр группийн, амьжиргааны хувьд орлого нь хувцас хунар авахад хүрэлцдэггүй хүмүүс жин дарж байна.

[16] Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.

График 33. Та “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)




Фокус бүлгийн ярилцлагын дүнгээс харахад, “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэх үг бол иргэдийн дунд бараг үнэн болсон ойлголт бөгөөд тэд хуулийн хэрэгжилтийг түр зуурын, шударга бус, ялгаатай гэж харж байна. Ийнхүү үзэж буй үндэслэлийг тайлбарлахдаа, хууль хэрэгжих хугацаа богино, тогтвортой бус, дарга, эрх мэдэлтэй хүмүүст үйлчлэхгүй, жирийн иргэдэд илүү хатуу үйлчилдэг гэжээ.

“Монголын хууль танил, талтай хүнд л үйлчилдэг” буюу хууль бүх хүнд эрх тэгш үйлчлэх чиг үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхийг үнэлүүлэхэд дундаж үнэлгээ

1.6 гарсан. Тодруулбал, “Монголын хууль танил, талтай хүнд л үйлчилдэг” гэдэг үгтэй судалгаанд оролцогчдын 86% нь санал нийлж байгаа бол 6% нь дунд зэрэг, 6% нь санал нийлэхгүй байна гэж хариулжээ.

График 34. **Та “Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ?**

Дундаж үнэлгээ: 1.6



Тайлбар: *Огт санал нийлэхгүй бол 5, бүрэн санал нийлж байгаа бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад аймаг, орон нутагт амьдарч буй байршил, насны бүлэг, ажил эрхлэлт, амьжиргааны хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 23. Та “Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[17]
Оршин суугаа газар	**0.127**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.036**
Насны бүлэг	**0.010**
Хүйс	**0.810**
Боловсролын түвшин	**0.085**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.314**
Амьжиргаа	**0.029**


[17] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

“Монголын хууль танил, талтай хүнд л үйлчилдэг” буюу хууль бүх хүнд эрх тэгш үйлчлэх чиг үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхийг үнэлүүлж, хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдахгүй буюу жигд тархалттай байна.

“Монголын хууль танил, талтай хүнд л үйлчилдэг” гэдэг үгтэй санал нийлэхгүй байгаа дүн бусадтай харьцуулахад өндөр нийгмийн бүлгийг харвал, аймгийн болон сумын төвд амьдардаг, 18-24 настай, малчин, амьжиргааны хувьд орлого нь машин авахад хүрэлцдэггүй хүмүүс байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу “Монголын хууль танил, талтай хүнд л үйлчилдэг” гэдэг үгтэй санал нийлж буй нийгмийн бүлэгт хөдөө амьдардаг, 25-44 настай, хувийн хэвшилд ажилладаг, орлого нь хоол хувцас хунар авахад хүрэлцдэггүй болон орлогоос илүү гарснаа хуримтлуулдаг хүмүүс жин дарж байна.

График 35. **Та “Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? *(Хүн ам зүйн үзүүлэлтээр)***




Фокус бүлгийн ярилцлагын хүрээнд "Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг" гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх эсэхийг тодруулахад, иргэдийн дийлэнх нь хууль тогтоомжийг шударга бус, танил талд үйлчилдэг тогтолцоо гэж харж, Монголын хуульд итгэх итгэлийн хамгийн том хямралын нэг гэж дүгнэж байна. Шалтгааныг тодруулахад, аливаа хууль хэрэгжихдээ танил тал, ар өврийн хаалга, ойр дотнын харилцаанд тулгуурлаж, хэл амтай хүмүүст үйлчилдэг гэжээ.

Судалгаанд оролцогчдоос "Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу?" гэж асууж, 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 3.3 гарсан. Тодруулбал, өөрт болон эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол гарч байгаагүй гэж судалгаанд оролцогчдын 44% нь, дунд зэрэг 11%, гарч байсан гэж 29% нь хариулжээ.

График 36. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу?

Дундаж үнэлгээ: 3.3



Тайлбар: *Огт үгүй бол 5, маш их бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад, оршин суугаа газар, аймаг, орон нутагт амьдарч буй байршил, насны бүлэг, хүйс, боловсрол, ажил эрхлэлт, өрхийн дундаж орлогын хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 24. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[18]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.000**
Насны бүлэг	**0.010**
Хүйс	**0.010**
Боловсролын түвшин	**0.000**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.000**
Амьжиргаа	**0.071**


“Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу?” асуулт хариултын дүнг , хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, судалгаанд оролцогчдын боловсрол, ажил эрхлэлтийн хувьд өндөр ялгаа ажиглагдсан бол бусад үзүүлэлтээр төдийлөн өндөр ялгаа ажиглагдаагүй буюу жигд тархалттай байна.

“Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу?” гэдэг үгтэй санал нийлэхгүй байгаа дүн бусадтай харьцуулахад өндөр нийгмийн бүлгийг харвал, аймаг, орон нутагт аймгийн болон сумын төвд амьдардаг, 55-аас дээш настай, бүрэн бус дунд хүртэлх боловсролтой, тэтгэвэр, группэд байдаг болон малчин, 400,000-1,200,000 төгрөгийн өрхийн дундаж орлоготой хүмүүс байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу тус үгтэй санал нийлж буй нийгмийн бүлэгт Улаанбаатар хот болон хөдөө амьдардаг, 18-34 настай, тусгай дунд болон магистраас дээш зэргийн боловсролтой, хувийн хэвшилд ажилладаг болон оюутан сурагч, 4,000,000-аас дээш дундаж орлоготой хүмүүс жин дарж байна.

[18] Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.

График 37. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)



Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? Гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 29% нь тийм гэж хариулсан.

Ийнхүү хариулсан хүмүүсээр ямар асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй болохыг тодруулахад давхардсан тоогоор 485 асуудал нэрлэсэн бөгөөд тус дүнг 100%-д шилжүүлж Хүснэгт 25 дахь үр дүнг харууллаа.

Тус дүнгээс харвал, иргэдийн хамгийн том гомдол бол шударга шийдвэр гаргах тогтолцооны доголдол бөгөөд энэ нь бусад салбар (эрүүл мэнд, газар, байр, нийгмийн үйлчилгээ) дахь үл итгэх байдал, бухимдлын суурь шалтгаан болж байна. Тодруулбал:

- ✓ Иргэдийн хамгийн их гомдол, үл итгэх хандлага нь хуулийн байгууллагууд шударга, ил тод шийдвэр гаргадаггүй, гомдлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэхгүй байгаа байдалд төвлөрч байна.
- ✓ Мөн эрүүл мэнд, газар, байр, зам тээврийн осол, авлига зэрэг амьдралд ойр салбарууд иргэдийн эрхийг зөрчиж буй томоохон асуудал гарсан.
- ✓ Энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн сулрал, төрийн байгууллагын хариуцлагын дутагдал, авлига, тэгш бус байдал нь иргэдийн хуульд итгэх итгэлийг доройтуулж буйг илтгэж байна.

Хүснэгт 25. Хуулиар шийдвэрлэж чадаагүй ямар асуудал байсан бэ?

№	Тохиолдол	Хувь	№	Тохиолдол	Хувь
1	Гомдлын мэдээлэл өгөхөд хуулийн дагуу шийдвэрлээгүй	47%	**18**	Малаа хулгайд алдаад шийдээгүй	1%
2	Эмч нар харьцаа муутай	7%	**19**	Хувийн нууц	1%
3	Газар асуудлыг танил, мөнгөтэй хүмүүсийн талд шийдвэр гаргаж байна	7%	**20**	Бодитой биш машины торгуулиудыг шийдвэрлэж өгөхгүй иргэн торгуулсан	0.4%
4	Байрны залилан	6%	**21**	Авто зогсоол	0.2%
5	Төрд итгэх итгэл алга болсон	5%	**22**	Бэлчээрийн асуудал	0.2%
6	Зам тээврийн осол	5%	**23**	Даатгалын байгууллагын буруутай үйлдэл	0.2%
7	Авлига, хээл хахуул	4%	**24**	Малчдын хооронд худаг ус талбайгаа булаацалдах	0.2%
8	Зөрчлийн тухай хуулиар хохирол амсахад тэр хохирлын улс авдаг хохирогч нь авдаггүй	3%	**25**	Үйлдвэрийн осолд орсон шийдвэр гараагүй	0.2%
9	Байгууллагаасаа цалингаа авч чадаагүй	2%	**26**	Хуулийн мэдлэг муу болохоор мэдлэггүй байна	0.2%
10	Гэр бүлийн асуудалд хууль, үйлчилгээний хувьд муу	2%	**27**	Хүүхдийн гэмт хэргийн асуудал	0.2%
11	Гэр бүлийн маргаан	1%	**28**	Цахилгаан тоолуураас маргаан	0.2%
12	Банк, санхүү зээлийн асуудал	1%	**29**	Гаалийн асуудал	0.2%
13	Тэтгэвэр буруу тогтоосон	1%	**30**	Орон нутгийн өмчид шахаа ож ирдэг	0.2%
14	Халамжийн үйлчилгээ	1%	**31**	Цэрэг татлага	0.2%

15	Гэр бүлийн асуудалд шүүх буруу шийдвэр гаргасан	1%	**32**	Төрийн өмчит компани өөрийн дураар мөнгө нэмдэг	0.2%
16	Боловсрол	1%	**33**	Улсын бүртгэл	0.2%
17	Хүний эрх эрх чөлөө хуулиар боомилдог	1%	**Нийт**		**100%**

Фокус бүлгийн ярилцлагын хүрээнд өөрт болон эргэн тойрны хүмүүст нь тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан эсэхийг тодруулахад, газрын маргаан, зам тээврийн ослоос үүдэлтэй эрүүл мэндийн хохирол, цагдаагийн байгууллагын албан хаагч өөрөө зөрчил гаргадаг асуудал, гэр бүл салалт зэрэг асуудлыг хамгийн их нэрлэжээ.


Тав. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

УИХ-ын гишүүн нь УИХ-ын сонгуулиар ард иргэдийн саналыг авч, УИХ-д ард түмний засаглах эрхийг төлөөлдөг субъект юм. Энэ агуулгаараа тойргоос болон жагсаалтаар сонгогдсон гишүүд шууд утгаараа ард түмний төлөөлөл болон ажиллаж, хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, иргэдийн санал хүсэлтийг хууль тогтоомжид тусган, дуу хоолойг илэрхийлэх үүрэгтэй билээ.

Тиймээс УИХ-ын гишүүний чиг үүргийн хэрэгжилтийг хэмжихдээ, ард түмний засаглах эрхийг хангах буюу төлөөллийн үүргээ тойргоос болон жагсаалтаар сонгогдсон гишүүд хэрхэн хангаж буйг харгалзсан болно.

УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 2.5 гарсан. Тус дундаж үнэлгээг гаргахад авч үзсэн 3 хүчин зүйлийн үнэлгээг харвал, УИХ-ын гишүүдийг ерөнхийд нь үнэлсэн байдал хамгийн өндөр байсан. Харин тойргоос сонгогдсон гишүүд төлөөллийн чиг үүргээ хангаж буй байдлын дундаж үнэлгээ жагсаалтын гишүүдээс бага зэрэг өндөр байна.

График 38. УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ




Тайлбар: *Маш сайн бол 5, маш муу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Нийт УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.7 гарсан. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 5% нь сайн, 46% нь дунд зэрэг, 43% нь муу үнэлгээ өгсөн байна.

График 39. Та нийт УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ?

Дундаж үнэлгээ: 2.7



Тайлбар: *Маш сайн бол 5, маш муу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос одоогийн УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байгаа талаар тодруулахад, иргэдийн олонх нь одоогийн гишүүдийн үйл ажиллагаа хангалтгүй, өгсөн амлалтаа хэрэгжүүлдэггүй, хууль тогтоомжийн хэрэгжилт сул гэж дүгнэж байна.


Тэгвэл одоо ямар хүлээлттэй байгаа талаар асуухад амлалтаа биелүүлэх, авлигагүй шударга ажиллах, амьдралын чанарыг бодитоор сайжруулах, нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийх зэрэг шаардлагыг тавьж байна. Тодруулбал:

- ✓ *Авлигын эрсэг хуулийг чангаруулж, хэрэгжүүлэлтэд анхаарах;*
- ✓ *Амьдралын чанар, эдийн засгийг сайжруулах хүрээнд залуучуудыг ажлын байраар хангах, цалин тэтгэврийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтөд анхаарах хэрэгтэй;*
- ✓ *Нийгмийн салбарт анхаарахдаа, боловсролын салбарт анхаарч багш нарын ачааллыг бууруулж, сургалтын төлбөрийг бууруулах, эрүүл мэндийн салбар, эмч сувилагчийн ачааллыг бууруулж, нөхцөлийг сайжруулах шаардлагатай;*
- ✓ *Улс орны хөгжлийн бодлогын хувьд, үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалж, үр дүнтэй бүтээн байгуулалтыг дэмжих хэрэгтэй гэжээ.*

Тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд иргэдийн төлөөлөл болж ажиллаж чадаж байгаа эсэхийг 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.4 гарсан. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 12% нь тус асуултад тийм, 27% нь дунд зэрэг, 46% нь үгүй гэж хариулсан байна.

График 40. Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу?

Дундаж үнэлгээ: 2.4



Тайлбар: *Хангалттай бол 5, огт үгүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад, оршин суугаа газар, насны бүлэг, боловсрол, ажил эрхлэлтийн хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 26. Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[19]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.658**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.206**
Боловсролын түвшин	**0.049**
Ажил эрхлэлт	**0.003**
Өрхийн дундаж орлого	**0.275**
Амьжиргаа	**0.438**


[19] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

“Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу?” гэсэн асуулт хариултын дүнг , хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдаагүй буюу жигд тархалттай байна.

Тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд иргэдийн төлөөл ажиллаж чадаж байна гэж үзэх нийгмийн бүлэгт аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 настай, бага сургуулийн боловсролтой, оюутан сурагч болон малчид илүү жин дарж байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу УИХ-ын гишүүд иргэдийн төлөөлөл болж ажиллаж чадахгүй байна гэж үзэх нийгмийн бүлэгт Улаанбаатар хотод амьдардаг, 25-44 нас, 55-аас дээш настай, магистраас дээш боловсролтой, хувийн хэвшилд ажилладаг, тэтгэвэр группийн болон цалинтай ажил эрхэлдэггүй хүмүүс илүү байна.


График 41. Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)



Намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж ажиллаж чадаж байгаа эсэхийг 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.3 гарсан. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 10% нь тус асуултад тийм, 21% нь дунд зэрэг, 55% нь үгүй гэж хариулсан байна.

График 42. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу?

Дундаж үнэлгээ: 2.3



Тайлбар: *Хангалттай бол 5, огт үгүй бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад, оршин суугаа газар, насны бүлэг, хүйс, боловсрол, ажил эрхлэлт, өрхийн дундаж орлогын хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 27. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[20]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.675**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.018**
Боловсролын түвшин	**0.000**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.048**
Амьжиргаа	**0.419**

“Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу?” гэсэн асуулт хариултын дүнг , хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдаагүй буюу жигд тархалттай байна.


Намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөл ажиллаж чадаж байна гэж үзэх нийгмийн бүлэгт аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 настай, бага сургуулийн

[20] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

боловсролтой, оюутан сурагч болон малчид, 400,000-1,200,000 төгрөгийн өрхийн дундаж орлого хүмүүс жин дарж байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж ажиллаж чадахгүй байна гэж үзэх нийгмийн бүлэгт Улаанбаатар хотод амьдардаг, 45-54 настай, тусгай дунд болон магистраас дээш боловсролтой, хувийн хэвшилд ажилладаг, 400,000 хүртэлх болон 4,000,000-аас дээш өрхийн орлоготой иргэд илүү байна.

График 43. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)




Зургаа. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэхдээ, өрхийн болон улс орны эдийн засгийн нөхцөл байдлын төсөөлөл хийгээд улс орны хөгжлийн чиг хандлагыг хэрхэн харж буйг харгалзсан.

Иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын төсөөллийн дундаж үнэлгээ 2.4 байна. Хамаарах 3 хүчин зүйлийг харьцуулж харвал, иргэдийн өрхийн эдийн засгийн нөхцөл байдал сайжирсан гэх дүн хамгийн өндөр буюу 2.6 байгаа бол Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлын үнэлгээ хамгийн бага буюу 2.3 гарчээ.

Харин Монгол Улсын хөгжлийн чиг хандлагыг буруу чиглэл рүү явж байна гэж үзэх хандлага жин дарж байгаа буюу дундаж үнэлгээ 2.4 гарсан болно.

График 44. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын үнэлгээ




Тайлбар: *Маш сайн бол 5, маш муу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Судалгаанд оролцогчдоос “Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу?” гэж асууж 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.4 гарсан.

Тус дүнг задалж харвал, Монгол Улс буруу чиглэл рүүгээ явж байна гэж иргэдийн 51% буюу 2 хүн тутмын нэг нь үзэж байгаа нь зөв чиглэл рүү явж байна гэсэн дүнгээс 5 дахин өндөр дүн байна.

График 45. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу?

Дундаж: 2.4



Тайлбар: *Маш зөв бол 5, маш буруу бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад, оршин суугаа газар, насны бүлэг, ажил эрхлэлт, өрхийн дундаж орлогын хувьд ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 28. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[21]
Оршин суугаа газар	**0.004**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.510**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.074**
Боловсролын түвшин	**0.069**
Ажил эрхлэлт	**0.007**
Өрхийн дундаж орлого	**0.021**
Амьжиргаа	**0.078**


[21] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

“Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу?” гэсэн асуулт хариултын дүнг , хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдаагүй буюу жигд тархалттай байна.

Монгол Улс зөв чиглэл рүү явж байна гэж үзэх нийгмийн бүлэгт 18-34 болон 55-аас дээш настай, төрийн албанд ажилладаг, оюутан сурагч, тэтгэвэр, группэд байдаг болон малчид, 400,000-800,000, 4,000,000-аас дээш төгрөгийн өрхийн дундаж орлого хүмүүс жин дарж байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу Монгол Улс буруу чиглэл рүү явж байна гэж үзэх нийгмийн бүлэгт 35-54 настай, хувийн хэвшилд ажилладаг болон цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй, 400,000 хүртэлх өрхийн дундаж орлоготой хүмүүс илүү байна.

График 46. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)



Фокус бүлгийн ярилцлагын хүрээнд Монгол Улс зөв чиглэл рүү явж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгүүлж, шалтгааныг тодруулахад, Монгол Улс буруу чиглэл рүү явж байна гэж хариулсан дүн жин дарж байна. Энэ нь эдийн засгийн хүндрэл, гадаадын нөлөө, баялгийн зохицуулалт, төрийн бодлогын сулралтай шууд холбоотой гэж тайлбарласан. Тодруулбал,


- ✓ *Монгол Улс буруу чиглэл рүү явж байна гэж үзэхдээ,*
  - *Үнийн өсөлтөөс үүдэлтэй иргэдийн амьжиргаа доройтож, өр зээл их болсон нь олон хүүхэдтэй өрхүүдэд дарамт болж байна.*
  - *Монгол Улс БНХАУ-аас хараат болж, тусгаар тогтнолын асуудал нэн тэргүүний тулгамдсан асуудал болсон.*
  - *Байгалийн баялгийн бодлого алдагдсан. Тухайлбал, байгалийн баялгаа зөв ашиглахгүй, нөхөн сэргээлт хийдэггүй. Гадагшаа хямд үнээр гаргаж, буцааж өндөр үнээр авч байна.*
  - *Төрийн өмчит компаниуд үргэлж ашиггүй ажилладаг нь төр хамгийн муу менежер болохыг баталж байна зэрэг асуудлыг хөндсөн.*
- ✓ *Монгол Улс зөв чиглэл рүү явж байна гэж цөөн хүн үзэхдээ, Монгол Улс зөв замаа сонгоод 30 жил болж байна, засах зүйл их байгаа ч ололтоо алдаж болохгүй гэсэн.*

Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.3 гарсан.

Тус дүнг задалж үншвал Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал дордсон гэж судалгаанд оролцогчдын 56% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 6 нь үзэж байгаа нь сайжирсан гэх үзүүлэлтээс 6 дахин өндөр дүн байна.

График 47. Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ?

Дундаж: 2.3



Тайлбар: *Маш их сайжирсан бол 5, маш их дордсон бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад, оршин суугаа газар, насны бүлэг, амьжиргааны түвшингээр ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 29. Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[22]
Оршин суугаа газар	**0.039**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.171**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.104**
Боловсролын түвшин	**0.360**
Ажил эрхлэлт	**0.070**
Өрхийн дундаж орлого	**0.290**
Амьжиргаа	**0.002**


“Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ?” гэсэн асуулт хариултын дүнг , хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдаагүй буюу жигд тархалттай байна.

Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байна гэж үзэх нийгмийн бүлэгт аймаг, орон нутагт амьдардаг, 18-24 настай, санхүүгийн асуудалгүй хүмүүс жин дарж байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал дордож байна гэж үзэх нийгмийн бүлэгт Улаанбаатар хотод амьдардаг, 35-аас дээш настай, өрхийн орлого нь хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй хүмүүс илүү байна.

[22] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

График 48. Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)



Фокус бүлгийн ярилцлагаар Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлын талаарх байр суурийг тодруулахад, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд итгэл сул, "муугаас муу болж байна" гэж үзэж байна. Иймхүү дүгнэх болсон үндэслэл нь:


- ✓ *Үнийн өсөлт, инфляц: Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс үүдэж иргэдийн цалин, тэтгэвэр хүрэлцэхгүй байна.*
- ✓ *Мөнгөний ханш, өрийн дарамт: Мөнгөний ханш унаж, иргэд зээлээс зээлийн хоорондамьдарч байхад татвар дарамт болж байна.*
- ✓ *Ядуурал, ажлын байр: Хүрэлцэхүйц цалин хөлстэй, эрүүл ажлын байр байхгүйгээс ядуурал нэмэгдэж байна.*
- ✓ *Авлига, үр ашиггүй төсөл: Үр ашиггүй олон төсөл хэрэгжүүлж байна. Төрийн тендер, худалдан авалт нь авлигын хэрэгсэл болсон. Төрийн өмчит компаниуд улс төрийн зорилгоор ашиглагдах болсон.*
- ✓ *Байгалийн баялгийн зохицуулалт: Оюу толгойгоос өөр эдийн засгийн эх үүсвэргүй. Тус төсөл нь Монгол Улсад хангалттай хэмжээний үр өгөөжөө өгдөггүй, хөрөнгө оруулагч талд ашигтай. Малын түүхий эдээ дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл бүрдээгүй зэрэг байна.*

Айл, өрхийн эдийн засгийн нөхцөл байдлыг 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.6 гарсан.

Тус дүнг задалж үншвал өрхийн эдийн засгийн нөхцөл байдал дордсон гэж судалгаанд оролцогчдын 43% буюу ойролцоогоор 10 хүн тутмын 4 нь үзэж байгаа нь сайжирсан гэх үзүүлэлтээс 3 дахин өндөр дүн байна.

График 49. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү?

Дундаж: 2.6



Тайлбар: *Маш их сайжирсан бол 5, маш их дордсон бол 1, 1-ээс 5 хүртэлх тоогоор үнэлүүлсэн. Дундаж үнэлгээг гаргахдаа хэлж мэдэхгүй гэсэн хариултыг хасаж, үнэлгээ өгсөн дүнд тулгуурласан болно.*

Тус асуулт дахь хариултын дүнг судалгаанд оролцогчдын хүн зүйн үзүүлэлтээр харьцуулж, хамаарлыг харахад, оршин суугаа газар, насны бүлэг, хүйс, ажил эрхлэлт, өрхийн дундаж орлого, амьжиргааны түвшингээр ялгаатай үр дүн гарсан.

Хүснэгт 30. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? (Хүн ам зүйн үзүүлэлтээр хамаарлын шинжилгээ)

Хүн ам зүйн мэдээлэл	Pearson Chi-Square: p value[23]
Оршин суугаа газар	**0.000**
Оршин суугаа байршил (аймаг, орон нутаг)	**0.788**
Насны бүлэг	**0.000**
Хүйс	**0.017**
Боловсролын түвшин	**0.213**
Ажил эрхлэлт	**0.000**
Өрхийн дундаж орлого	**0.008**
Амьжиргаа	**0.000**


[23] *Pearson Chi-Square: p value < 0.05 бол хоёр хувьсагч хооронд статистикийн хамаарал байна гэж үзнэ.*

“Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? гэсэн асуулт хариултын дүнг , хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулж харахад, төдийлөн өндөр ялгаа ажиглагдаагүй буюу жигд тархалттай байна.

Өрхийн эдийн засгийн нөхцөл байдал сайжирсан гэж үзэх нийгмийн бүлэгт аймаг, орон нутагт амьдардаг, 18-34 настай, эрэгтэй, төрийн албанд ажилладаг, оюутан сурагч болон малчид, 1,800,000-аас дээш төгрөгийн орлоготой, амьжиргааны хувьд санхүүгийн асуудалгүй хүмүүс жин дарж байна.

Харин, дунджаас бага үнэлгээ өгсөн буюу өрхийн эдийн засгийн нөхцөл байдал дордож байна гэж үзэх нийгмийн бүлэгт Улаанбаатар хотод амьдардаг, 35-54 настай , хувийн хэвшилд ажилладаг болон цалинтай хөдөлмөр эрхэлдэггүй, тэтгэвэр группийн, 400,000 төгрөг хүртэлх өрхийн орлоготой, амьжиргааны хувьд өрхийн орлого нь хоол хүнсэндээ ч хүрэлцдэггүй хүмүүс илүү байна.


График 50. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? (Хүн ам зүйн үзүүлэлтээр)



Судалгаанд оролцогчид давхардсан тоогоор 4,437 хариулт өгснийг 100% гэж үзвэл эрүүл мэндийн үйлчилгээ, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, цалин хөлсний хүрэлцээгүй байдал, агаарын бохирдлын асуудал Монгол улсад нэн түрүүнд тулгамдсан асуудлаар нэрлэгдсэн байна.

Харин хүн нэг бүрээр харвал, иргэдийн 56% хувь буюу 2 хүн тутмын нэг нь эрүүл мэндийн үйлчилгээг тулгамдсан асуудлаар нэрлэсэн нь хамгийн өндөр байгаа бол өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг 43% нь, 25%-33% нь цалин хөлсний хүрэлцээгүй байдал, агаарын бохирдол, ядуурлыг нэрлэжээ.

График 51. Өнөөдөр манай улсад тулгамдаж буй хамгийн чухал асуудал юу байна вэ?



Фокус бүлгийн ярилцлагын дүнгээс иргэдэд тулгамдсан асуудлыг нэрлүүлэхэд:

- ✓ *Эдийн засаг, амьжиргаа:* ***Цалин, тэтгэврийн хүрэлцээ муу****, үнийн өсөлттэй хөл нийлүүлж чадахгүй байгаагаас ядуурал гарч авч байна. Мөн ажлын байрны хомсдол их байгааг дурдсан.*

- ✓ *Эрүүл мэнд: Өвчлөл, ялангуяа чихрийн шижин зэрэг архаг өвчин ихэссэн энэ үед эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар муу, ЭМД төлөөд ч үйлчилгээ авахад хүндрэлтэй байдаг.*
- ✓ *Боловсрол: Багш нарын цалин бага, нэг анги дахь хүүхдийн дүүргэлт хэтэрсэн зэргээс үүдэн боловсролын чанар доройтож байна.*
- ✓ *Байгаль орчин, уул уурхай: Уул уурхай, байгалийн баялгийг зөв ашиглаагүйгээс газрын доройтол, хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж, хүнсний ногооны импортын хараат байдалд орж байна.*
- ✓ *Авлига, шударга бус байдал: Төрийн байгууллагын шат шатан дахь авлигын асуудал бусад бүх асуудлын суурь шалтгаан болж байна.*
- ✓ *Бусад: Бензин шатахуун, тог цахилгааны үнийн нэмэгдэл, тогтвортой бус байдлыг нэрлэсэн.*

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөөг баталж, **хэрэгжилтэд жил тутам мониторинг** хийж, Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын хороонд танилцуулна” гэж шийдвэрлэсэн байдаг. Энэ удаад буюу 2025 онд суурь үнэлгээг тогтоох зорилгоор, үндэсний хэмжээнд 1,522 хүний түүвэртэй, асуулга болон фокус бүлгийн ярилцлагын аргыг хэрэглэж, үнэлгээг 1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлүүлж, учир шалтгааныг тодруулж, тайлагнасан болно.

Нэг. УИХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

УИХ-ын үйл ажиллагаанд хамаарах хүчин зүйлс нөлөөлсний дүнд дундаж үнэлгээ 2.2 гарсан. УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээнд аль хүчин зүйл нь хэрхэн нөлөөлж буйг шинжлэхэд хамгийн хүчтэй хувьсагч нь УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүрэг, удаах нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих УИХ-ын чиг үүрэг байсан бол УИХ-ын хууль санаачлах чиг үүрэг болон УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй байдал бага нөлөөтэй байна.

Тиймээс, УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээг сайжруулахын тулд нөлөөлөгч хүчин зүйлсэд анхаарч ажиллаж, дундаж үнэлгээг өсгөх боломжтой. Хэрвээ нөлөөлөгч хүчин зүйл тус бүрийн дундаж үнэлгээ нэг нэгжээр өсвөл УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээ доорх функтээр өсөх боломжтой юм. Үүнд:

- *УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүргийн дундаж үнэлгээ 2.5 байсан бөгөөд тус үнэлгээ нэг нэгжээр өсөхөд УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээ 0.367 функтээр өсөх;*
- *Эдийн засгийн нөхцөл байдлын дундаж үнэлгээ 2.4 байсан бөгөөд тус үнэлгээ нэг нэгжээр өсөхөд УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээ 0.201 функтээр өсөх;*
- *УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн дундаж үнэлгээ 2.5 байсан бөгөөд тус үнэлгээ нэг нэгжээр өсөхөд УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээ 0.183 функтээр өсөх;*
- *УИХ-ын хууль санаачлах чиг үүргийн дундаж үнэлгээ 2.6 байсан бөгөөд тус үнэлгээ нэг нэгжээр өсөхөд УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээ 0.084 функтээр өсөх;*
- *УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй эсэх дундаж үнэлгээ 2.4 байсан бөгөөд тус үнэлгээ нэг нэгжээр өсөхөд УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээ 0.084 функтээр өсөх.*

Одоогийн 126 гишүүнтэй парламентын үйл ажиллагааг өмнөх 76 гишүүнтэй парламенттай харьцуулан үнэлэхэд дундаж үзүүлэлт 2.2 гарсан нь дунджаас доогуур, сул түвшинд байгааг харуулж байна. Ийнхүү үнэлэгдэх болсон гол шалтгаан нь парламентын гишүүдийн тоо нэмэгдсэн боловч тэдний ажиллах чанар сайжраагүй, харин ч улсын төсөвт нэмэлт ачаалал учруулж, татвар төлөгчдийн санхүүгийн дарамтыг нэмэгдүүлж байна гэсэн хандлага давамгайлсантай холбоотой юм. Гэсэн хэдий ч зарим иргэд болон шинжээчид 126 гишүүнтэй болсон нь УИХ дахь төлөөллийн хүрээг өргөжүүлж, олон нийтийн санал бодлыг бодлого боловсруулах үйл явцад илүү өргөн тусгах нөхцөл бүрдүүлснээр, чанартай бөгөөд нийгэмд хэрэгцээтэй хууль тогтоомж батлагдах боломж нэмэгдэнэ гэсэн эерэг хүлээлттэй хэвээр байна.

УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн танилцуулсан “Парламент 2.0: Гурван төгөлдөршил” илтгэлийн талаарх иргэдийн мэдээлэл хангалтгүй байгаа нь дундаж үнэлгээ 1.4-өөс харагдаж байна. Судалгаанд оролцогчдын цөөн хэсэг нь энэхүү илтгэлийг төрийн байгууллагын илүүдэл орон тоо, ажлын зохион байгуулалт, дагалдах хууль тогтоомжийн алдаа зэрэг бодит асуудлыг хөндөж буй ач холбогдолтой гэж үнэлжээ. Харин олонх оролцогчид хууль санаачлах үйл ажиллагаа нь зарчмын хувьд зөв боловч татвар нэмэх, бодит амьдралд зөрчилтэй шийдвэрүүд гаргах эрсдэл дагуулж байна хэмээн шүүмжлэлтэй байр суурь илэрхийлсэн байна.

Парламент 2.0-ын “Гурван төгөлдөршил” бодлогын хүрээнд “Хүн төвтэй хууль эрх зүйн орчин бүрдүүлэх”, “Цаг үеийн шаардлагад нийцсэн хууль тогтоомж боловсруулах”, “Иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль эрх зүйн орчин бий болгох” гэсэн гурван зорилтыг тодорхойлсон байна. Эдгээр ойлголтыг иргэдэд танилцуулж, тэд хэрхэн хүлээн авч байгааг тодруулахад, нийтлэгээр зөвөөр ойлгож байгаа нь ажиглагджээ. Гэсэн хэдий ч өнөөгийн УИХ-ын үйл ажиллагааны нөхцөл байдлыг харгалзан үзэхэд энэхүү бодлого нь бодит амьдрал дээр бүрэн хэрэгжих боломжгүй, хэрэгжилтийн үр дүн сул байна гэсэн сөрөг хандлага давамгайлж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Тодруулбал,

- “Хүн төвтэй хууль эрх зүйн орчин”-ы хүрээнд иргэдийн дунд хандлага эерэг бус байна. Судалгаанд оролцогчдын үзэж буйгаар хууль, дүрэм журам нь энгийн иргэдэд хатуу үйлчилдэг боловч өндөр албан тушаал хашиж буй хүмүүс болон эрх мэдэлтнүүдэд адил тэгш хэрэгждэггүй гэж шүүмжилжээ. Мөн УИХ нь өөрсдөдөө ашигтай хууль тогтоомж батлах хандлагатай бөгөөд улсын төсвөөс хувийн ашиг сонирхолдоо завшсан тохиолдолд хууль хэрэгжихгүй байгаа нь “хүн төвтэй” зарчим алдагдаж буйг илтгэнэ гэж дүгнэсэн байна.
- “Цаг үеийн шаардлагад бүрэн нийцсэн хууль бий болгох” зорилгын хүрээнд одоогийн байдлаар бодитоор хэрэгжсэн, үр нөлөөтэй хууль тогтоомж батлагдаагүй гэж иргэд дүгнэж байна. Судалгаанд оролцогчид Эрүүгийн хууль,

Замын хөдөлгөөний тухай хууль, Зөрчлийн тухай хууль зэрэг нь хүний эрхийг хязгаарласан, ихэвчлэн торгууль ноогдуулах зорилго давамгайлсан зохицуулалттай байгаа талаар шүүмжлэлтэй, бухимдалтай байр суурь илэрхийлжээ.

- “Иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль, эрх зүйн орчин” гэсэн үзэл баримтлалын хүрээнд иргэдийн дунд зарим эерэг хүлээлт ажиглагдаж байна. Тухайлбал, УИХ-ын гишүүд шаардлагатай судалгаа хийж, чанартай хууль батлахад илүү анхаарах ёстой гэсэн байр суурь дэмжлэгтэй байна. Гэвч нөгөө талаас олон нийт хууль тогтоомжийн талаарх мэдлэг мэдээлэл дутмаг, зөвхөн өөрт хэрэгцээтэй үед нэг, хоёр заалттай танилцах түвшинд хязгаарлагдаж байгаа нь хууль, эрх зүйн боловсрол сул байгааг илтгэж байна.

Иймээс УИХ-ын стратеги төлөвлөлт болон хэрэгжилтийг хангахтай холбоотой үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэйгээр мэдээлэх шаардлагатай байна. Энэ үйл явцад иргэдийн хүлээлтэд нийцсэн бодлого боловсруулах нь онцгой ач холбогдолтой бөгөөд уг хүлээлт нь үндэсний хөгжил, шударга ёс, амьдралын чанар, авлига хээл хахуульгүй тэмцэл, эрүүл мэнд болон боловсролын салбарын дэмжлэг зэрэг чиглэлд төвлөрч байна. Түүнчлэн боловсруулсан бодлогын хэрэгжилтэд бодитой хяналт тавьж, гарч буй үр дүнг олон нийтэд хүртээмжтэй сувгаар ил тод хүргэх нь оновчтой гэж харагдаж байна.

Хоёр. УИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАЖ БУЙ БАЙДАЛ

УИХ-ын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж буй эсэхийг хэмжихдээ, УИХ-ын гишүүнд үйл ажиллагаагаа иргэдэд тайлагнах, санал хүсэлтийг сонсох, мэдээллийн эх сурвалжуудаар дамжуулан мэдээлэл өгөх замаар УИХ-ын үйл ажиллагааны талаарх ойлголт мэдлэг ойлголт нь хэр байгааг харгалзсан.

УИХ үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангаж буй эсэхийг дээрх 5 асуултаар үнэлүүлэхэд дундаж хэрэгжилт 2.4 гарсан.

Судалгаанд хамрагдсан таван үзүүлэлтийн дүнгээс харахад иргэд, олон нийт УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авах байдал болон түүнтэй холбоотой мэдлэг, ойлголтын түвшин дунджаас өндөр үнэлэгдсэн байна. Харин УИХ-ын үндсэн чиг үүргийн талаарх мэдлэг, УИХ-ын гишүүдийн сонгогчдод тайлагнах байдал, иргэдийн санал хүсэлтээ гишүүдэд илэрхийлэх боломж зэрэг үзүүлэлтүүд дунджаас доогуур үнэлэгджээ. Ялангуяа, иргэд УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг харьцангуй сайн авдаг хэдий ч, парламентын үндсэн чиг үүргийн талаарх ойлголт, мэдлэг хамгийн бага түвшинд байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Тодруулбал,

УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авах байдлын дундаж үнэлгээ 3 гэж гарсан бөгөөд иргэдийн 66%–77% буюу 10 хүн тутмын 7–8 нь фэйсбүүк болон телевизээр дамжуулан мэдээлэл авч байна. Мэдээллийн эх сурвалжаа сонгох байдал нь насны бүлгээр ялгаатай бөгөөд 18–34 насны залуучууд голчлон фэйсбүүк ашиглаж байгаа бол 35-аас дээш насныхан телевиз илүү үзэж буй нь судалгааны дүнгээс харагдаж байна..

Иргэдийн ихэнх нь фэйсбүүкээр мэдээлэл авах болсон нь гар утсаа ашиглан сошиал орчныг гүйлгэн үзэх явцдаа санамсаргүй байдлаар мэдээлэлтэй таарах боломж өндөр, хурдан бөгөөд хялбар мэдээлэл авах нөхцөл бүрдүүлдэгтэй холбоотой байна. Түүнчлэн фэйсбүүк нь найз нөхөдтэйгээ мэдээлэл хуваалцах, харилцаа тогтоох давуу талтай гэж үзэгдэж байна. Харин телевизийн хувьд цахим сүлжээтэй харьцуулахад мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдал, баталгаатай байдлыг илүүд үзсэн сонголт болж, иргэд УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг телевизээс авах нь түгээмэл байна.

Тэгэхээр УИХ-ын талаарх мэдээллийг иргэдэд хүргэхдээ ***цахим орчин дахь хүртээмж ба телевизийн итгэлцлийг хослуулах*** *нь үр дүнтэй гэж дүгнэж болохоор байна.*

Иргэд өөрсдийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж үзэж буй байдлыг тодруулахад дундаж үнэлгээ 2.7 гэж гарсан байна. Харин УИХ-ын чиг үүргийн талаарх мэдлэгийг тодорхойлох зорилгоор есөн хариултын хувилбар бүхий сорил өгч, зөв хариулт нэрлүүлэхэд судалгаанд оролцогчдын 28% нь 3–5 зөв хариулт сонгосон бол 55% нь зөвхөн 1–2 хариулт сонгожээ. Түүнчлэн нийт оролцогчдын 17% нь нэг ч зөв хариулт сонгоогүй нь иргэд, олон нийт УИХ-ын үндсэн чиг үүргийн талаар хангалтгүй ойлголттой байгааг илтгэж байна.

УИХ-ын чиг үүргийн талаарх ойлголтыг бататгах зорилгоор дахин асуухад “хууль санаачлах, батлах, нэмэлт өөрчлөлт оруулах”, “иргэдийн санал хүсэлтийг бодлого, хууль тогтоомжид тусгах”, “ард иргэдийн амьдралд чиглэсэн бодлого боловсруулах” зэрэг үндсэн чиг үүргийг зөв тодорхойлсон хариултууд давамгайлж байсан боловч нийтлэг түвшинд тодорхой бус ойлголт байсаар байна. Мөн ийм төрлийн зөв хариултыг өгсөн хүмүүсийн дийлэнх нь дунд болон түүнээс дээш, ялангуяа бакалаврын түвшнээс дээш боловсролтой иргэд байгааг судалгаа харуулж байна.

УИХ-ын чиг үүргийн талаар буруу буюу бүрхэг ойлголттой иргэдийн дунд “татвар, тэтгэврийн асуудлыг шийдвэрлэх”, “иргэдийн амьжиргааг шууд тодорхойлох”, эсвэл “УИХ бол зөвхөн хууль баталдаг байгууллага” гэх зэргээр хэт хялбаршуулсан тайлбар өгөх хандлага ажиглагдсан байна. Ийм төрлийн ойлголттой хүмүүсийн хувьд 18–24 насны залуучууд болон ахмад настнууд зонхилж байв.

Харин УИХ-ын чиг үүргийн талаар огт мэдэхгүй эсвэл ойлголтгүй гэж хариулсан бүлэг нь ихэвчлэн бага боловсролтой болон бүрэн бус дунд боловсролтой иргэдийн дунд давамгайлж байгааг судалгааны дүн харуулж байна.

Дээрхээс харвал, УИХ-ын чиг үүргийг цалин тэтгэвэр нэмж, иргэдийн амьжиргааг шийдвэрлэх ёстой гэх хандлагаас үүдэн УИХ-ын үндсэн чиг үүргийн мэдэхгүйгээс зөв үнэлэлт дүгнэлт хийх боломж иргэдийн дунд хязгаарлагдмал байна. Тиймээс иргэд, олон нийтэд УИХ-ын чиг үүргийн талаарх мэдлэг, ойлголтыг өгөхөд анхаарч ажиллах шаардлагатай байна.

УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнах, мөн иргэд, сонгогчдын санал хүсэлтийг авч үзэн бодлого боловсруулах нь тэдний үндсэн үүргийн нэг юм. Гэвч энэ чиглэлээр хийсэн үнэлгээний дүнгээс харахад, тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүдийн ажлаа тайлагнадаг байдалд өгсөн дундаж үнэлгээ 2.3 гарсан нь “муу” түвшинд байна. Мөн иргэдийн 72% нь УИХ-ын гишүүндээ санал бодлоо илэрхийлж байгаагүй бол зөвхөн 28% нь илэрхийлсэн гэж хариулжээ. Харин санал бодлоо илэрхийлсэн иргэдийн хувьд ч гишүүндээ санал хүсэлтээ хүргэх боломжийг 2.2 гэж үнэлсэн нь мөн л “муу” түвшинд байгааг харуулж байна.

Ийнхүү муу үнэлж буй шалтгааныг тодруулахад, УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэх боломж бараг байдаггүй, санал хүсэлтээ илэрхийлэх суваг байдаг ч хүлээж авдаггүй, хүлээж авсан ч бодитой үр дүнг гардаггүй гэж үзэж байна.

Санал хүсэлтээ УИХ-ын гишүүнд илэрхийлж байсан хүмүүс хурал, уулзалт дээр-47%, фэйсбүүк дээр сэтгэгдэл бичих хэлбэрээр-29% хамгийн их хандаж байсан бол бичгээр, жагсаал цуглаанд оролцох хэлбэрээр гэж 12%-18%, Улсын Их Хурлын үндсэн үйл ажиллагаа болох хууль тогтоох үйл хэрэгт иргэд, олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн “My D-Parliament” цахим системээр 9% нь санал хүсэлтээ илэрхийлж байжээ.

Иргэдийн зүгээс УИХ болон УИХ-ын гишүүнд санал бодлоо илэрхийлэх үр дүнтэй эх сурвалжийг дурдахдаа,

- *Иргэдтэй нүүр тулж уулзаж (хурал цуглаан зарлаж уулзах, уулзалт товлох, санал сонсдог өдөртэй болох) санал, хүсэлтийг сонсож, хэлэлцүүлэг зохион байгуулах;*
- *Цахим орчинд, нийгмийн сүлжээнд санал бодлоо илэрхийлэх, захидал бичих, албан ёсны и-мэйлээр илгээх гэх мэт орчин үеийн сувгийг ашиглаж иргэдийн санал хүсэлтийг УИХ, УИХ-ын гишүүд авч, эргээд хариу өгч, үр дүнтэй байхад анхаарах нь зүйтэй гэж харж байна.*

Гурав. УИХ-ЫН ХУУЛЬ САНААЧЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

УИХ хууль санаачлах чиг үүргээ хэрхэн хангаж буйг үнэлүүлэхдээ УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь уншихад ойлгомжтой байж, дагалдах дүрэм, журмын уялдаатай байдлыг хангаж, Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашгийг хамгаалж, улс орны хөгжилд эерэг өөрчлөлтийг авчирч чадаж байгаа эсэх талаарх иргэдийн үнэлгээнд тулгуурлаж гаргасан.

УИХ-ын хууль санаачлах чиг үүргийн дундаж үнэлгээ 2.6 гарсан. Үүнээс Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг гэж дундаж үзүүлэлт хамгийн өндөр байгаа бол хууль тогтоомжийн уялдаатай байдал, Үндэсний язгуур эрх ашиг, Монгол Улсын тусгаар тогтнол, эх орны хөгжилд нийцэж байгаа эсэх үнэлгээ дунджаас бага байна.

УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд нийцэхгүй байна гэж үзэх шалтгааныг харвал, гаднын улсын, тэр дундаа БНХАУ-ын нөлөөлөл их, Монгол Улсад олноор орж ирж байна. Мөн гаднын улсад байгалийн баялаг, уул уурхайгаа ашиглуулж, байгаль орчноо нөхөн сэргээхгүй байгаа бөгөөд иргэдийн амьдрал өдөр ирэх тусам доройтож байна гэсэн байр суурийг илэрхийлж байна.

Тиймээс иргэдэд Монгол Улсын гадаад харилцаа, түүний ач холбогдлын талаарх зөв мэдээллийг хүргэх, уул уурхай, ашигт малтмалын байгаль орчинд хохирол учруулахгүй байх чиглэлийн бодлогыг хүргэж, хэрэгжилтэд хяналт тавих хэрэгтэй гэж харагдаж байна.

Дөрөв. УИХ-ЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

УИХ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж чадаж буй эсэхийг хэмжихдээ, хууль тогтоомж нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд үзүүлэх нөлөөлөл, хэрэгжүүлэгч байгууллага болох төрийн байгууллагын үйлчилгээний нөхцөл байдал, хууль тогтоомж урт хугацаанд болон нийгэмд шинээр үүсэж асуудлыг зохицуулж, хүн бүрд тэгш үйлчилж байгаа эсэхийг харгалзсан.

УИХ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийг судалгаанд оролцогчид 2.5 буюу “дундаж” түвшинд үнэлжээ. Дунджаас өндөр үнэлгээ авсан үзүүлэлт нь төрийн байгууллагын үйлчилгээ болон аливаа асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх боломж хязгаарлагдмал ч тодорхой хэмжээнд оршин байгаа гэж

үзсэн явдал байв. Харин хамгийн бага үнэлгээ нь хууль хэрэгжүүлэх явцад иргэдэд эрх тэгш хандах зарчим алдагдаж, танил тал бүхий этгээдийн талд шийдвэр гарах нөхцөл бүрддэг гэсэн байр суурьтай холбоотой гарсан байна.

Судалгаанд оролцогчдын 27 хувь, өөрөөр хэлбэл ойролцоогоор дөрвөн хүн тутмын нэг нь төрийн байгууллагаас үйлчилгээ авах явцдаа эрх нь зөрчигдсөн мэдрэмж авсан гэж хариулжээ. Эрх зөрчигдсөн тохиолдлыг ангилж үзэхэд хамгийн өндөр хувь буюу 39% нь эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой байсан бол удаах 20% нь төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой асуудалд хамаарч байна. Мөн цагдаа, шүүхийн байгууллагатай холбоотой гомдол 13%, газрын маргаантай холбоотой 6.3%, нийгмийн халамж болон татварын байгууллагатай холбоотой 9%, боловсролын байгууллагатай холбоотой асуудал 4%-ийг эзэлжээ.

Төрийн байгууллагын бараг бүх салбарт иргэдийн хамгийн их шүүмжилж буй асуудал нь харилцаа, хандлага болон хүнд суртал байв. Ялангуяа эрүүл мэндийн салбарт оочир дараалал, үйлчилгээний хүртээмжийн хязгаарлалт, эрүүл мэндийн даатгалын төлбөрийн үр өгөөжийг бүрэн хүртэх боломжгүй байгаа талаар олон нийт дурдаж байна. Харин цагдаа, шүүхийн байгууллагын хувьд жирийн иргэдэд дарамт үзүүлэх, танил тал болон илүү их мөнгөтэй этгээдийн талд үйлчлэх хандлага давамгайлдаг гэсэн шүүмжлэл түгээмэл илэрхийлэгдсэн байна.

УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадахгүй байна гэж үзэж буй шалтгаан нь хууль тогтоогч буюу гишүүдийн чадвар сул, өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлж хууль баталдаг, баталсан хууль нь мөнгөтэй, танил талтай хүний талд үйлчилдэг зэргийг дурдаж, эцэстээ иргэдийн амьдралын чанарт эергээр нөлөөлөхгүй байна гэжээ.

Хууль хүн бүрд ижил тэгш, урт хугацаанд тогтвортой үйлчилж чаддаггүй гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь үзсэн. Ийнхүү үнэлэхдээ, хууль хэрэгжих хугацаа богино, тогтвортой бус, дарга, эрх мэдэлтэй хүмүүст үйлчлэхгүй, жирийн иргэдэд илүү хатуу үйлчилдэг зэрэг үндэслэлийг тайлбарлаж байлаа.

Иргэдэд тулгарсан аливаа асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол судалгаанд оролцогчдын 29%-д тохиолдсон. Эдгээр хүмүүсээс ямар асуудал байсныг тодруулахад, иргэдийн хамгийн том гомдол бол шударга шийдвэр гаргах тогтолцооны доголдол бөгөөд энэ нь бусад салбар (эрүүл мэнд, газар, байр, нийгмийн үйлчилгээ) дахь үл итгэх байдал, бухимдлын суурь шалтгаан болж байна.

Тиймээс хууль иргэн бүрд тэгш үйлчлэх тогтолцоог бий болгох, өөрөөр хэлбэл, хийсэн хэрэгт нь тохирсон шийтгэл оногдуулдаг байхад хууль хэрэгжүүлэгч байгууллага анхаарах шаардлага нэн тэргүүнд тулгарч байна. Мөн хууль урт хугацаанд үйлчилсээр байдаг ч мөнгө, танил тал, эрх мэдэлтэй хүний хувьд энэхүү

шинж чанар нь алдагдаж байна гэх иргэдийн сөрөг ойлголтод анхаарч ажиллах шаардлагатай байна.

Тав. УИХ-ЫН ГИШҮҮНИЙ ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРЭГ

УИХ-ын гишүүн нь УИХ-ын сонгуулиар ард иргэдийн саналыг авч, УИХ-д ард түмний засаглах эрхийг төлөөлдөг субъект юм. Энэ агуулгаараа тойргоос болон жагсаалтаар сонгогдсон гишүүд шууд утгаараа ард түмний төлөөлөл болон ажиллаж, хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, иргэдийн санал хүсэлтийг хууль тогтоомжид тусган, дуу хоолойг илэрхийлэх үүрэгтэй билээ.

Энэ агуулгаар УИХ-ын гишүүний чиг үүргийн хэрэгжилтийг хэмжихдээ, ард түмний засаглах эрхийг хангах буюу төлөөллийн үүргээ тойргоос болон жагсаалтаар сонгогдсон гишүүд хэрхэн хангаж буйг харгалзсан.

Судалгааны дүнгээс харвал, УИХ-ын гишүүний төлөөллийн чиг үүргийн дундаж үзүүлэлт 2.5 гарсан. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааны үнэлгээ дунджаас өндөр гарсан ч гишүүдийн үйл ажиллагаа хангалтгүй, өгсөн амлалтдаа хүрдэггүй гэх шалтгаанаар тойргоос болон жагсаалтаар сонгогдсон гишүүд төлөөллийн чиг үүргээ биелүүлж буй байдлыг харьцангуй муу гэж үнэлсэн. *Тиймээс УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааны үнэлгээг сайжруулахын тулд амлалтаа биелүүлэх, авлигагүй шударга ажиллах, амьдралын чанарыг бодитоор сайжруулах, нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийх зэрэгт анхаарч ажиллах шаардлагатай байна.*

Зургаа. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэхдээ, өрхийн болон улс орны эдийн засгийн нөхцөл байдлын төсөөлөл хийгээд улс орны хөгжлийн чиг хандлагыг хэрхэн харж буйг харгалзсан.

Иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын төсөөллийн дундаж үнэлгээ 2.4 буюу дунджаас бага үнэлгээ авсан. Тодруулбал, иргэдийн өрхийн эдийн засгийн нөхцөл байдал бага зэрэг сайжирсан ч Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал муудсан. Энэ агуулгаараа иргэд Монгол Улсын ирээдүйн чиг хандлагыг сөргөөр харах нь илүү байна.

Нийгэмд үнийн өсөлт, өр зээлээс үүдэлтэй амьжиргааны доройтол бий болж, урд хөрш болох БНХАУ-аас хараат болж, байгалийн баялгаа хямд үнээр гадагшаа гаргаж, өндөр үнээр буцаан авч, төр муу менежер хийснээс үүдэн төрийн өмчит компаниуд ашиггүй ажиллаж байгаа нь Монгол Улс буруу чиглэл рүү явж буйн илрэл гэж иргэдийн зүгээс үзэж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг муудсан гэж үзэхдээ, үнийн өсөлт, инфляц, өрийн дарамт, ядуурал, ажлын байрны хомсдол, авлига, үр ашиггүй төсөл, байгалийн баялгийн буруу зохицуулалт, хуваарилалтын асуудлыг үндэс болгон шүүмжлэлтэй байр суурийг илэрхийлжээ.


Өмнө хэлсэнчлэн УИХ-ын үйл ажиллагааны үнэлгээнд хүчтэй нөлөөлөх нэг хүчин зүйл нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал юм. Энэ агуулгаар дээрх тулгамдсан асуудлуудад гарц шийдэл олж, иргэдийн амьдралд эерэг өөрчлөлтийг авчрах бодлого төлөвлөх нь зүйтэй гэж харагдаж байна.

Хавсралт (харьцуулсан үр дүнгийн график)

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ, НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ


Хавсралт график 1. Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Оршин суугаа газраар)

Дундаж: **2.3** **2.5**




Хавсралт график 2. Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Насны бүлэг, хүйсээр)


Дундаж: **2.5** **2.4** **2.3** **2.4** **2.4** **2.3** **2.4**




Хавсралт график 3. Та ер нь УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Ажил эрхлэлтээр)




Хавсралт график 4. Одоогийн 126 гишүүнтэй парламент 76 гишүүнтэй байсан өмнөх парламенттай харьцуулахад хэр зэрэг ажиллаж байна гэж Та бодож байна вэ? (Оршин суугаа газар, байршлаар)




Хавсралт график 5. Одоогийн 126 гишүүнтэй парламент 76 гишүүнтэй байсан өмнөх парламенттай харьцуулахад хэр зэрэг ажиллаж байна гэж Та бодож байна вэ? (Насны бүлэг, хүйсээр)




Хавсралт график 6. Одоогийн 126 гишүүнтэй парламент 76 гишүүнтэй байсан өмнөх парламенттай харьцуулахад хэр зэрэг ажиллаж байна гэж Та бодож байна вэ? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)



Хавсралт график 7. Одоогийн 126 гишүүнтэй парламент 76 гишүүнтэй байсан өмнөх парламенттай харьцуулахад хэр зэрэг ажиллаж байна гэж Та бодож байна вэ? (Амьжиргааны түвшнээр)




Хавсралт график 8. Та УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн танилцуулсан Парламент 2.0 "Гурван төгөлдөршил" илтгэлийн талаар мэдээлэлтэй байгаа юу? (Оршин суугаа газар, байршлаар)




Хавсралт график 9. Та УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн танилцуулсан Парламент 2.0 "Гурван төгөлдөршил" илтгэлийн талаар мэдээлэлтэй байгаа юу? (Насны бүлэг, хүйсээр)

Дундаж:1.2 1.3 1.4 1.5 1.7 1.5 1.4




Хавсралт график 10. Та УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн танилцуулсан Парламент 2.0 "Гурван төгөлдөршил" илтгэлийн талаар мэдээлэлтэй байгаа юу? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)

Дундаж:




Хавсралт график 11. Та УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн танилцуулсан Парламент 2.0 "Гурван төгөлдөршил" илтгэлийн талаар мэдээлэлтэй байгаа юу? (Өрхийн дундаж орлогоор)




Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАЖ БУЙ БАЙДАЛ


Хавсралт график 12. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ? (Оршин суугаа газар, байршлаар)



Хавсралт график 13. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ? (Насны бүлэг, хүйсээр)




Хавсралт график 14. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)




Хавсралт график 15. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр зэрэг авдаг вэ? (Өрхийн дундаж орлого, амьжиргааны түвшнээр)

Дундаж:




Хавсралт график 16. Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ? (Насны бүлэг, хүйсээр)

Дундаж: 2.5 2.6 2.7 2.8 2.9 2.8 2.6



Хавсралт график 17. Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)

Дундаж:




Хавсралт график 18. Та өөрийгөө УИХ-ын үйл ажиллагааг хэр зэрэг мэддэг гэж бодож байна вэ? (Өрхийн дундаж орлого, амьжиргаагаар)

Дундаж:




Хавсралт график 19. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? (Оршин суугаа газраар)

Дундаж: **2.1** **2.5**




Хавсралт график 20. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? (Хүйсээр)

Дундаж: **2.3** **2.4**




Хавсралт график 21. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)

Дундаж:




Хавсралт график 22. Танай тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүд хийсэн ажлаа тайлагнадаг уу? (Амьжиргааны түвшнээр)


Дундаж: 2.1 2.3 2.4 2.4 2.5 2.5 2.4




Хавсралт график 23. Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу? (Оршин суугаа байршлаар)



Хавсралт график 24. Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу? (Боловсролын түвшнээр)




Хавсралт график 25. Таны хувьд УИХ-ын гишүүнд санал хүсэлтээ илэрхийлэхэд хялбар байдаг уу? (Амьжиргааны түвшнээр)



Гурав. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ САНААЧЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ


Хавсралт график 26. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? (Оршин суугаа газраар)

Дундаж: **2.4** **2.5**




Хавсралт график 27. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? (Насны бүлэг, хүйсээр)

Дундаж: **2.8** **2.5** **2.4** **2.4** **2.4** **2.5** **2.4**




Хавсралт график 28. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь Үндэсний язгуур эрх ашиг буюу Монгол Улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх ашиг, эх орны хөгжилд хэр зэрэг нийцэж байна вэ? (Ажил эрхлэлтээр)

Дундаж: 2.6 2.4 2.9 2.4 2.4 2.5




Хавсралт график 29. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу? (Оршин суугаа газраар)

Дундаж: 2.2 2.4




Хавсралт график 30. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу? (Насны бүлэг, хүйсээр)

Дундаж: 2.7 2.4 2.3 2.3 2.1 2.3 2.3




Хавсралт график 31. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу? (Ажил эрхлэлтээр)


Дундаж: 2.5 2.3 2.8 2.1 2.3 2.4




Хавсралт график 32. Таны бодлоор Монголын хууль, дагалдах дүрэм, журам нь харилцан уялдаатай байж, асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чаддаг уу? (Амьжиргааны түвшнээр)




Хавсралт график 33. Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу? (Оршин суугаа газраар)



Хавсралт график 34. Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу? (Насны бүлэг, хүйсээр)




Хавсралт график 35. Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)



Хавсралт график 36. Таны бодлоор Монголын хууль, тогтоомжийг уншихад ойлгомжтой байдаг уу? (Өрхийн дундаж орлого, амьжиргааны түвшнээр)


Дундаж:




Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Хавсралт график 37. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү? (Оршин суугаа газраар)

Дундаж: 3 3.4




Хавсралт график 38. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү? (Насны бүлэг, хүйсээр)




Хавсралт график 39. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)

Дундаж:




Хавсралт график 40. Өнгөрсөн онд төрийн байгууллагаас (яам, шүүх, цагдаа, ЗДТГ, эмнэлэг сургууль, татвар, нийгмийн даатгал гэх мэт) ямар нэг үйлчилгээ авахад Таны эрх зөрчигдөж байгаа мэт мэдрэмж төрсөн үү? (Өрхийн дундаж орлогоор)

Дундаж: **3.5** **3.6** **3.3** **3.2** **3.2** **3.1** **2.9**




Хавсралт график 41. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу? (Оршин суугаа газраар)


Дундаж: **2.1** **2.4**



Хавсралт график 42. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу? (Насны бүлгээр)




Хавсралт график 43. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)




Хавсралт график 44. Таны бодлоор УИХ-аас баталж буй хуулиуд нь иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулж чадаж байна уу? (Өрхийн дундаж орлого, амьжиргааны түвшнээр)

Дундаж:




Хавсралт график 45. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу? (Оршин суугаа газраар)


Дундаж:




Хавсралт график 46. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу? (Насны бүлгээр)




Хавсралт график 47. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу? (Ажил эрхлэлтээр)



Хавсралт график 48. Таны бодлоор УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомж нь урт хугацаанд улс оронд хөгжил авчрах, иргэдийн амьдралыг сайжруулахад эерэг нөлөөтэй байж чаддаг уу? (Амьжиргааны түвшнээр)




Хавсралт график 49. **Та “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Насны бүлэг, хүйсээр)**




Хавсралт график 50. **Та “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)**

Дундаж:




Хавсралт график 51. **Та “Монголын хууль 3 хоног л үйлчилдэг” гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Амьжиргааны түвшнээр)**


Дундаж:




Хавсралт график 52. Та "Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг" гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Оршин суугаа байршлаар)




Хавсралт график 53. Та "Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг" гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Насны бүлгээр)



Хавсралт график 54. Та "Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг" гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Ажил эрхлэлтээр)




Хавсралт график 55. Та "Монголын хууль танил, талтай хүнд илүү үйлчилдэг" гэдэг үгтэй хэр зэрэг санал нэгдэх вэ? (Амьжиргааны түвшнээр)




Хавсралт график 56. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? (Оршин суугаа газар, байршлаар)

Дундаж: 3.1 3.5 3.5 3.5 3.1




Хавсралт график 57. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? (Насны бүлэг, хүйсээр)


Дундаж: 3.1 3.1 3.2 3.4 3.7 3.3 3.3



Хавсралт график 58. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)




Хавсралт график 59. Танд болон таны эргэн тойрны хүмүүст тулгарсан асуудлыг хуулиар шийдвэрлэж чадаагүй тохиолдол байсан уу? (Өрхийн дундаж орлогоор)



Тав. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ


Хавсралт график 60. Та нийт УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ? (Оршин суугаа газраар)

Дундаж: **2.4** **2.6**




Хавсралт график 61. Та нийт УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ? (Насны бүлэг, хүйсээр)

Дундаж: **2.6** **2.5** **2.4** **2.5** **2.4** **2.4** **2.5**




Хавсралт график 62. Та нийт УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)

Дундаж:




Хавсралт график 63. Та нийт УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна вэ? (Амьжиргааны түвшнээр)


Дундаж: 2.3 2.5 2.4 2.6 2.5 2.6 2.6




Хавсралт график 64. Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Оршин суугаа газраар)




Хавсралт график 65. Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Насны бүлгээр)




Хавсралт график 66. Танай тойргоос сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)




Хавсралт график 67. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Оршин суугаа газраар)



Хавсралт график 68. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Насны бүлэг, хүйсээр)




Хавсралт график 69. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Боловсролын түвшин, ажил эрхлэлтээр)



Хавсралт график 70. Таны бодлоор намын жагсаалтаар сонгогдсон гишүүд иргэдийн төлөөлөл болж чадаж байна уу? (Өрхийн дундаж орлогоор)


Дундаж: 2.1 2.4 2.4 2.2 2.3 2.3 2.1



Зургаа. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Хавсралт график 71. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу? (Оршин суургаа газраар)

Дундаж: 2.4 2.4




Хавсралт график 72. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу? (Насны бүлгээр)


Дундаж: 2.5 2.5 2.3 2.3 2.5



Хавсралт график 73. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу? (Ажил эрхлэлтээр)




Хавсралт график 74. Таны бодлоор Монгол Улс ерөнхийдөө зөв чиглэл рүү явж байна уу эсвэл буруу чиглэл рүү явж байна уу? (Өрхийн дундаж орлогоор)




Хавсралт график 75. Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Оршин суугаа газраар)

Дундаж: **2.2** **2.3**



Хавсралт график 76. Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Насны бүлгээр)

Дундаж: **2.5** **2.3** **2.2** **2.2** **2.2**




Хавсралт график 77. Та Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь хэрхэн дүгнэж байна вэ? (Амьжиргааны түвшнээр)


Дундаж:2.1 **2.2** **2.2** **2.3** **2.3** **2.5** **2.5**




Хавсралт график 78. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? (Оршин суугаа газраар)



Хавсралт график 79. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? (Насны бүлэг, хүйсээр)



Хавсралт график 80. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? (Ажил эрхлэлтээр)



Хавсралт график 81. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? (Өрхийн дундаж орлого, амьжиргааны түвшнээр)

Дундаж:

